Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2020 оны 100 тоот тушаалын
7 дугаар хавсралт

Дорнод аймгийн Боловсролын газар

2026 ОНЫ ХАГАС ЖИЛ-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

| № | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэл-ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| Нэг. Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээ | | | | | | | |
| 1.1. | Хүн бүрт чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, боловсролын чанарыг дээшлүүлэн, үндэсний хэмжээнд өрсөлдөх чадвартай хүний нөөцийг бэлтгэнэ. | 200.0 сая Аймгийн ОНХС | Хэрэгжилтийн хувь | 100 | 100 | Зорилтын хүрээнд 9 арга хэмжээ төлөвлөн хэрэгжилтийг 100 хувь ханган ажиллалаа. | 100% |
| 1.1.1 | Сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсрол, мэргэжлийн болон дээд боловсролын үйлчилгээг салбарын хууль, тогтоомж, | Зохион байгуулалтын арга хэмжээ | Хэрэгжилтийн хувь | 100 | Эхний хагас жилд: 100<br>Жилийн эцэст: 100 | Аймгийн хэмжээнд СӨБ-ын 32 байгууллагад 6517 хүүхэд, 1021 ажилтан, ЕБС-ийн 27 сургуульд 20786 суралцагч, 1596 ажилтан, мэргэжлийн | 100% |

**Эх сурвалж:** *А.Мөнхжаргал /Статистикийн мэдээлэл, хяналт, шинжилгээ үнэлгээ хариуцсан ахлах арга зүйч/*
*Дорнод аймгийн Боловсролын газар, Бодлогын хэрэгжилтийн хэлтэс, 304 тоот, Емэйл: munkhjargal6lgv@moes.edu.mn Утас: 89336089*

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | шийдвэрийн дагуу тухайн орон нутагтаа зохион байгуулна | | | | | боловсролын байгууллагад 1176 суралцагч, 136 ажилтан, МУИС-ийн Зүүн бүсийн сургуульд 445 оюутан, 64 ажилтан суралцаж, ажиллаж байгаа бөгөөд Насан туршийн суралцахуйн 1 төв үйл ажиллагаа явуулж байна. 2026 онд боловсролын салбарт Засгийн газрын тогтоол, үндсэн чиглэл 13, сайдын болон Боловсролын ерөнхий газрын даргын тушаал, журам 16, орон нутгийн шийдвэр, стандарт 14 зэрэг нийт 53 эрх зүйн акт, зөвлөмж, чиглэл, үүрэг даалгаврыг бүх шатны байгууллагад хүргүүлж, хэрэгжилтэд нь хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ. Бодлого, шийдвэрийн хэрэгжилтийг | |

***Эх сурвалж:*** *А.Мөнхжаргал /Статистикийн мэдээлэл, хяналт, шинжилгээ үнэлгээ хариуцсан ахлах арга зүйч/*
*Дорнод аймгийн Боловсролын газар, Бодлогын хэрэгжилтийн хэлтэс, 304 тоот, Емэйл: munkhjargal6lgv@moes.edu.mn Утас: 89336089*

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | сайжруулах хүрээнд сургуулийн өмнөх боловсролын 31 байгууллага, ерөнхий боловсролын 22 сургуулийн удирдлагатай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, 4 удаагийн сургалт, зөвлөгөөнөөр 57 байгууллагын 120 албан хаагчид арга зүйн дэмжлэг үзүүлэв. Мөн 31 цэцэрлэгийн эрхлэгч, арга зүйч, багш, багшийн туслах ажилтнуудад хууль, дүрэм, сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах чиглэлээр 6 удаагийн сургалт зохион байгуулж, давхардсан тоогоор 638 хүнийг хамрууллаа. Боловсролын ерөнхий хууль шинэчлэгдсэнтэй холбогдуулан | |

***Эх сурвалж:*** *А.Мөнхжаргал /Статистикийн мэдээлэл, хяналт, шинжилгээ үнэлгээ хариуцсан ахлах арга зүйч/*
*Дорнод аймгийн Боловсролын газар, Бодлогын хэрэгжилтийн хэлтэс, 304 тоот, Емэйл: munkhjargal6lgv@moes.edu.mn Утас: 89336089*

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | сургуулийн өмнөх боловсролд мөрдөх 33 төрлийн эрх зүйн акт, дүрэм, журмыг эмхэтгэн 32 цэцэрлэгийн удирдах ажилтнуудад хүргэж, хэрэгжилтийг ханган ажиллав. Аймгийн ИТХ-ын шийдвэрээр хүүхэд, багшийн хөгжлийг дэмжих 6 төсөл, арга хэмжээ, сургалтын орчныг сайжруулах 19 арга хэмжээг аймаг, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлэн хэрэгжүүлж байна. Түүнчлэн “Боловсролыг дэмжих жил”-ийн хүрээнд төлөвлөсөн 59 арга хэмжээнээс эхний хагас жилд 28-ыг хэрэгжүүлж, багшийн хөгжил, дижитал шилжилт, сурагчдын хөгжил хамгаалал, мэргэжил сонголт, хүртээмжтэй боловсролыг дэмжсэн бодит үр | |

***Эх сурвалж:*** *А.Мөнхжаргал /Статистикийн мэдээлэл, хяналт, шинжилгээ үнэлгээ хариуцсан ахлах арга зүйч/*
*Дорнод аймгийн Боловсролын газар, Бодлогын хэрэгжилтийн хэлтэс, 304 тоот, Емэйл: munkhjargal6lgv@moes.edu.mn Утас: 89336089*

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | дүнд хүрч, боловсролын байгууллагуудын хамтын ажиллагаа, сургалтын чанар, хүртээмж сайжирлаа.<br>Хүрсэн түвшин: 100<br>Хавсралт: 9 файл | |
| 1.1.2 | Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтыг нэмэгдүүлнэ. | Зохион байгуулалтын арга хэмжээ | Хамран сургалтын хувь | 94.2 | Эхний хагас жилд: 94.2<br>Жилийн эцэст: 94.5 | 2025-2026 оны хичээлийн жилд 32 цэцэрлэгийн 234 бүлэгт 6495 хүүхэд сурч байна. Үүнээс үндсэн бүлэгт 6365, хувилбарт бүлэгт 130 хүүхэд байна. Хэрлэн сумын 7 дугаар багт байршилтай Төрийн бус өмчийн “Сэргэлэн багачууд” цэцэрлэгийн барилгыг түрээсийн гэрээгээр Хэрлэн сумын 12 дугаар цэцэрлэгийн салбар бүлгийн зориулалтаар ашиглаж байгаа ба түрээсийн төлбөрийн 63.0 сая төгрөгийг орон нутгийн төсөвт тусгуулан | 100% |

***Эх сурвалж:*** *А.Мөнхжаргал /Статистикийн мэдээлэл, хяналт, шинжилгээ үнэлгээ хариуцсан ахлах арга зүйч/*
*Дорнод аймгийн Боловсролын газар, Бодлогын хэрэгжилтийн хэлтэс, 304 тоот, Емэйл: munkhjargal6lgv@moes.edu.mn Утас: 89336089*

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | батлуулан 150 хүүхдийг хамруулан сургаж байна. 2026 онд 11 дүгээр багт 150 ортой шинэ цэцэрлэг ашиглалтад оруулж, 2 бүлэг шинээр нээж, элсэлтийг нэмэгдүүлснээр хамрагдалт 0.7 хувиар нэмэгдэж, хамран сургалт 94.9 хувьд хүрсэн.<br>Хүрсэн түвшин: 94.9<br>Хавсралт: 1 файл | |
| 1.1.3 | Таван настай бүх хүүхдийг сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд бүрэн хамруулна. | Зохион байгуулалтын арга хэмжээ | Хамран сургалтын хувь | 98.4 | Эхний хагас жилд: 98.4<br>Жилийн эцэст: 98.6 | Тойргийн 5 настай 1956 хүүхдээс сургуулийн өмнөх боловсролын ердийн болон хувилбарт сургалтаар 1922 хүүхдийг хамруулсан сургалаа. Хамран сургалт 98.46 хувьд хүрсэн. Үүнээс цэцэрлэгийн өдрийн бүлгээр хамрагдах боломжгүй алслагдсан малчдын болон хилийн заставын | 100% |

**Эх сурвалж:** *А.Мөнхжаргал /Статистикийн мэдээлэл, хяналт, шинжилгээ үнэлгээ хариуцсан ахлах арга зүйч/*
*Дорнод аймгийн Боловсролын газар, Бодлогын хэрэгжилтийн хэлтэс, 304 тоот, Емэйл: munkhjargal6lgv@moes.edu.mn Утас: 89336089*

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ажилчдын 21 хүүхдийг гэр бүлд суурилсан сургалт үйл ажиллагаанд хамруулсан.<br>Хүрсэн түвшин: 98.46<br>Хавсралт: 1 файл | |
| 1.1.4 | Цэцэрлэгийн насны ялгаатай хэрэгцээтэй хүүхдийн сургуулийн өмнөх боловсролд хамрагдалтыг нэмэгдүүлнэ. | Зохион байгуулалтын арга хэмжээ | Хамран сургалтын хувь | 82.2 | Эхний хагас жилд: 82.2<br>Жилийн эцэст: 82.4 | Дорнод аймгийн хэмжээнд цэцэрлэгийн насны 96 хүүхэд бүртгэлтэй байгаагаас 10 хүүхэд байнгын асаргаа шаардлагатай тул суралцах боломжгүй байна. 2026 оны эхний хагас жилийн байдлаар, аймгийн 24 цэцэрлэгт нийт 86 хүүхэд суралцаж байгаа нь цэцэрлэгт хамрагдах боломжтой хүүхдүүдийн 89.5 хувийг эзэлж байна. Энэ нь өмнөх хичээлийн жилээс хамрагдалт 7.3 хувиар өссөн үзүүлэлт гарсан. 2026 оны эхний хагас жилийн | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байдлаар цэцэрлэгт хамрагдаагүй байгаа хөгжлийн ялгаатай 10 хүүхдийг хамран сургах тойргийн цэцэрлэгт нь хамруулах зорилгоор судалгаа, мэдээллийг нэгтгэн ажиллаж байна.<br>Хүрсэн түвшин: 89.5<br>Хавсралт: 2 файл | |
| 1.1.5 | Сургуулийн насны ялгаатай хэрэгцээтэй хүүхдийг ерөнхий боловсролын сургуульд хамрагдалтыг нэмэгдүүлнэ. | Зохион байгуулалтын арга хэмжээ | Хамран сургалтын хувь | 80 | Эхний хагас жилд: 80<br>Жилийн эцэст: 80.5 | Аймгийн хэмжээнд 6–18 насны ялгаатай хэрэгцээтэй 296 хүүхэд байгаагаас 54 нь байнгын асаргаатай, суралцах боломжгүй, 242 нь ерөнхий боловсролд хамрагдах боломжтой бөгөөд 2025–2026 оны хичээлийн жилд 23 сургуульд 202 хүүхэд (83%) сурч байна. Бүх сурагчид эрүүл мэндийн оношилгоонд 100 хувь бүрэн хамрагдсан байна. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Эцэг эх, асран хамгаалагчдын хүсэлтэд үндэслэн 107 хүүхдэд ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж байна. Мөшгөх судалгаагаар илэрсэн, хүнд нөхцөлд амьдарч буй болон хөгжлийн ялгаатай байдлын улмаас сургуульд хамрагдаж чадаагүй 25 хүүхдийн мэдээллийн санг шинээр үүсгэн, хяналтыг тогтоосон. Танхимын сургалтад хамрагдах боломжгүй, байнгын асаргаа шаардлагатай эдгээр хүүхдүүдийг гэр бүл, орон нутгийн онцлогт нь нийцүүлэн хувилбарт болон цахим сургалтад хамруулах зорилготой "Гэрт хүрэх багц" төслийг Орон нутгийн | |

**Эх сурвалж:** *А.Мөнхжаргал /Статистикийн мэдээлэл, хяналт, шинжилгээ үнэлгээ хариуцсан ахлах арга зүйч/*
*Дорнод аймгийн Боловсролын газар, Бодлогын хэрэгжилтийн хэлтэс, 304 тоот, Емэйл: munkhjargal6lgv@moes.edu.mn Утас: 89336089*

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хөгжлийн сангийн 20.0 сая төгрөгөөр хэрэгжүүлэхээр аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолоор батлуулсан бөгөөд сургалтын материалыг худалдан авах ажиллагаа дуусч, хүлээн авах комисс ажиллаж байна.. Боловсролын хүртээмжтэй орчныг бүрдүүлэх, тусгай хэрэгцээт суралцагчдыг дэмжих чиглэлээр Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн 32.3 сая төгрөгийн хөрөнгөөр Хэрлэн сумын 2, 5, 8, 11, 12 дугаар сургууль болон Хан-Уул, Шинэ хөгжил сургуулиудад ялгаатай хэрэгцээт суралцагчдад зориулсан ариун цэврийн өрөөний иж бүрдэл тоноглолыг шийдвэрлэв. Энэхүү ажлын хүрээнд стандартын шаардлага хангасан | |



*Дорнод аймгийн Боловсролын газар, Бодлогын хэрэгжилтийн хэлтэс, 304 тоот, Емэйл: munkhjargal6lgv@moes.edu.mn Утас: 89336089*

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 9 нэр төрлийн 190 ширхэг суултуур, шээлтүүр, тулгуур бариул зэрэг тусгай тоноглолуудыг нийлүүлж, сургуулийн орчныг хүүхдэд ээлтэй, тэгш хүртээмжтэй болгон сайжруулаа. Хүрсэн түвшин: 83.47 Хавсралт: 3 файл | |
| 1.1.6 | Хичээлийн жилийн бүтцийг мөрдөх, гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн үед хичээл, сургалтыг тасралтгүй үргэлжлүүлэх бэлэн байдлыг хангах, цахим платформыг сургалтад нэвтрүүлэх арга хэмжээ хэрэгжүүлнэ. | Зохион байгуулалтын арга хэмжээ | Хэрэгжилтийн хувь | 100 | Эхний хагас жилд: 100<br>Жилийн эцэст: 100 | Хичээлийн жилд бүх шатны боловсролын 61 байгууллага гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн үед сургалтыг тасралтгүй, тэгш хүртээмжтэй зохион байгуулах бэлэн байдлыг хангаж ажиллаж байна. Бүх шатны боловсролын байгууллагууд 100% интернетэд холбогдсон бөгөөд Аймгийн орон нутгийн төсвийн 43.0 сая төгрөгийн хөрөнгөөр цахим | 100% |

***Эх сурвалж:*** *А.Мөнхжаргал /Статистикийн мэдээлэл, хяналт, шинжилгээ үнэлгээ хариуцсан ахлах арга зүйч/*
*Дорнод аймгийн Боловсролын газар, Бодлогын хэрэгжилтийн хэлтэс, 304 тоот, Емэйл: munkhjargal6lgv@moes.edu.mn Утас: 89336089*

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ангийн 11 нэр төрлийн 22 ширхэг тоног төхөөрөмжийг Хэрлэн сумын 12-р сургууль, 2-р сургуулиудад нийлүүлснээр ерөнхий 13 сургуульд 22, Политехник коллеж 6 цахим сургалтын танхимтай, МУИС-ийн Зүүн бүсийн сургууль 1 цахим танхимтай болсон. 1 компьютерт 9.13 сурагч ногдож, СӨБ, ЕБС-ийн багш нарын 86.7%, МБСБ-ын багш нар 100% компьютерээр хангагдсан. Сургуулиуд цахим платформыг хөгжүүлэх, ашиглах, багш нар цахим контент, хичээл бэлтгэх, сурагчид цахим хичээлд хамрагдах боломж бүрдсэн. Цахим платформд суурилсан сургуулийн өмнөх боловсролын 224 багш 4 сургалтад, ерөнхий | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | боловсролын 27 сургуулийн 906 багш 26 сургалтад хамрагдаж, цахим орчинд сургалт зохион байгуулах мэдлэг ур чадварыг сайжрууллаа. Мэргэжлийн багшийн болон анги удирдсан багшийн сарын ажлын төлөвлөгөөнд ангийн хичээлээс гадуурх ажил, бататгах хичээлийг 14 хоногт 1 удаа зайнаас зохион байгуулахаар төлөвлөхөөс гадна сургалтын явц, үр дүнг үнэлэх аппликэйшн, цахим аялал интерактив хичээлийн сан, 6-8 программуудыг сургалтад нээлттэй, үр дүнтэй ашиглаж хэвшсэн.<br>Хүрсэн түвшин: 100<br>Хавсралт: 2 файл | |
| 1.1.7 | Улсын физикийн 37-р олимпиадыг зохион байгуулна. | 200.0 сая ОНХС | Хэрэгжилтийн хувь Туршилтын багаж хэрэглэгдэхүүн | - | Эхний хагас жилд: Хэрэгжилтийн хувь 100 Туршилтын багаж | Дорнод аймгийн Баяндун сумын харьяат, Монгол Улсын анхны | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | нийлүүлсэн сургуулийн тоо - 1 | | хэрэглэгдэхүүн нийлүүлсэн сургууль - 18 Жилийн эцэст: - | онолын физикч, нэрт эрдэмтэн Дугаржавын Цэрэнгийн нэрэмжит Улсын физикийн XXXVII олимпиадыг 2026 оны 04 дүгээр сарын 04-07-ны өдрүүдэд Дорнод аймгийн Чойбалсан хотноо амжилттай зохион байгууллаа. Тус олимпиадыг Боловсролын яам, Боловсролын ерөнхий газар, Монгол Улсын их сургууль, Шинжлэх ухаан, технологийн их сургууль, Монгол Улсын Боловсролын их сургууль болон Монголын физикийн олимпиадын хороо хамтран зохион байгуулсан бөгөөд үйл ажиллагаанд 21 аймаг, 9 дүүргээс шалгарсан 13-74 насны нийт 152 багш, сурагч, 100 гаруй зочид, эрдэмтэн докторууд хүрэлцэн ирж оролцов. | |

**Эх сурвалж:** А.Мөнхжаргал /*Статистикийн мэдээлэл, хяналт, шинжилгээ үнэлгээ хариуцсан ахлах арга зүйч/*
*Дорнод аймгийн Боловсролын газар, Бодлогын хэрэгжилтийн хэлтэс, 304 тоот, Емэйл: munkhjargal6lgv@moes.edu.mn Утас: 89336089*

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Олимпиадын орон нутгийн зохион байгуулалт, өрсөлдөөн өндөр түвшинд явагдсан бөгөөд Дорнод аймгаас оролцсон багийн гишүүдээс нэг багш, хоёр сурагч шагналт байр эзэлж, Улсын физикийн олимпиадын хүрэл медаль хүртсэн амжилтыг үзүүллээ. Түүнчлэн энэ удаагийн олимпиадыг олон улсын жишигт нийцүүлэх чиглэлд онцгой анхаарч, их, дээд сургуулийн багш нарын бүтээсэн туршилтын дэвшилтэт багаж хэрэгслүүдийг ашигласан төдийгүй, тэмцээний үр дүнг бодитой тооцоход ухаалаг технологийг амжилттай нэвтрүүлэн ажиллав. Улсын физикийн олимпиадыг орон | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | нутагтаа өндөр түвшинд зохион байгуулахад зориулж аймгийн төсвөөс нийт 200.0 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэн гаргасан бөгөөд тус хөрөнгө оруулалтын хүрээнд олимпиадын зохион байгуулалтын зардлыг санхүүжүүлэхийн зэрэгцээ орон нутгийн төрийн өмчийн 23 сургуулийн физикийн кабинетыг шинэчлэхэд зориулж 48.0 сая төгрөгийн үнэ бүхий шаардлагатай тоног төхөөрөмжүүдийг иж бүрнээр нь шийдвэрлэн хүлээлгэн өглөө.<br>Хүрсэн түвшин: Хэрэгжилт - 100% Туршилтын багаж хэрэглэгдэхүүн нийлүүлсэн сургууль - 23<br>Хавсралт: 5 файл | |

**Эх сурвалж:** А.Мөнхжаргал /Статистикийн мэдээлэл, хяналт, шинжилгээ үнэлгээ хариуцсан ахлах арга зүйч/
Дорнод аймгийн Боловсролын газар, Бодлогын хэрэгжилтийн хэлтэс, 304 тоот, Емэйл: munkhjargal6lgv@moes.edu.mn Утас: 89336089

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.1.8 | Сургуулийн өмнөх болон бага боловсролын сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд удирдлага, арга зүйн дэмжлэг үзүүлж, зохион байгуулалтын нэгдсэн зохицуулалтаар хангана. | Зохион байгуулалтын арга хэмжээ | Хэрэгжилтийн хувь | 100 | Эхний хагас жилд: 100<br>Жилийн эцэст: 100 | Сургуулийн өмнөх боловсролын шинэчилсэн хөтөлбөрийг хэрэгжүүлэх, багш нарт арга зүйн дэмжлэг үзүүлж үндэсний хэмжээний сургалтад 13 багш, удирдлагыг хамруулан орон нутгийн сургагч багшаар бэлтгэлээ. Үүний дагуу "Боловсролын хөгжлийн манлайлал" ТББ-тай хамтран цахим болон танхим хосолсон цуврал сургалтыг зохион байгуулж, аймгийн хэмжээний 31 цэцэрлэгийн 274 багш, 33 арга зүйч болон удирдах ажилтнуудыг хамруулан шинэчилсэн хөтөлбөрийн үзэл баримтлал, арга зүйн нэгдсэн ойлголт өгч, мэргэжлийн 2 кредитийн батламж олгов. Түүнчлэн | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Сэргэлэн, Баяндун, Баян-Уул, Цагаан-Овоо сумдын багш нарт зориулсан бүсчилсэн сургалтыг дадлагад суурилсан 13 сэдвийн хүрээнд хийж, шинэ үеийн техник технологи, цахим программын шийдлүүдийг заах зөвлөлөө. Ялангуяа "Чанга уншлага" болон "Зохиолд суурилсан арга зүй"-г бүх цэцэрлэгт түгээн дэлгэрүүлснээр хөтөлбөрийг хэрэгжүүлэх нэгдмэл арга зүй бүрдэж, багш нарын заах арга барил, мэргэжлийн чадавхад чанарын ахиц гарлаа. Бага боловсролын шинэчилсэн хөтөлбөрийг хэрэгжүүлэх, багш нарт арга зүйн дэмжлэг үзүүлэх бэлтгэл ажлын хүрээнд Боловсролын сайдын 2026 оны | |

***Эх сурвалж:*** *А.Мөнхжаргал /Статистикийн мэдээлэл, хяналт, шинжилгээ үнэлгээ хариуцсан ахлах арга зүйч/*
*Дорнод аймгийн Боловсролын газар, Бодлогын хэрэгжилтийн хэлтэс, 304 тоот, Емэйл: munkhjargal6lgv@moes.edu.mn Утас: 89336089*

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | А/46 дугаар тушаалаар батлагдсан “Сургалтын хөтөлбөр шинэчлэн батлах тухай” хавсралтыг сургалтын менежерүүдэд танилцуулж, судлах чиглэлээр хангав. Менежерүүдийн манлайллын хүрээнд хөтөлбөрийн үзэл баримтлал, эрх зүйн үндэслэл, үнэлгээ, 3 дугаар ангиас судлах "Компьютерын ухаан" судлагдахууны арга зүйн сургалт, хэлэлцүүлгийг зохион байгууллаа. Уг арга хэмжээнд 26 сургуулийн 26 сургалтын менежер, 285 анги удирдсан багш болон дуу хөгжим, биеийн тамирын нарийн мэргэжлийн багш нар 100 хувь хамрагдсан байна. Сургалтын үр дүнд 1–5 дугаар ангийн | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | багш нар судлагдахууны агуулга, арга зүй, үнэлгээний чиглэлээр шинэ хичээлийн жилд хэрэгжүүлэх нэгдсэн мэдлэг, мэдээлэлтэй болж, цахим танхим, техник тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг ханган ажиллалаа.<br>Хүрсэн түвшин: 100<br>Хавсралт: 2 файл | |
| 1.1.9 | "Боловсролыг дэмжих жил"-ийн хүрээнд боловсролын чанарыг сайжруулах, хүртээмжийг нэмэгдүүлэх, орон нутгийн хүн амд үзүүлэх боловсролын чанар, хүртээмж, үр ашгийг дээшлүүлэхэд чиглэсэн арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлнэ. | 1.4 тэрбум | Хэрэгжилтийн хувь | - | Эхний хагас жилд: 100<br>Жилийн эцэст: 100 | Зорилтот жилийн хүрээнд нийт 59 ажил төлөвлөн хагас жилийн байдлаар 43 арга хэмжээг, үүнээс Боловсролын чанарыг сайжруулах, багш нарыг чадавхжуулах чиглэлээр 20, Хүртээмжийг нэмэгдүүлэх, удирдлага, албан хаагчдыг дэмжих чиглэлээр 11, Орон нутгийн хүн амд үзүүлэх үр ашгийг | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | дээшлүүлэх, сурах орчныг сайжруулах чиглэлээр 12 арга хэмжээг тус тус хэрэгжүүллээ. Боловсролын чанарыг сайжруулах, багш нарыг чадавхжуулах чиглэлээр 26 сургуулийн 1127 багшийг дижитал технологийн сургалтад хамруулж, 50 зөвлөх багшаар дамжуулан 450 багшид ялгаатай арга зүй түгээв. 44 сургалтын менежер, 42 арга зүйч мэргэжлийн бүлгийн ажилд хамрагдаж чадавхаа дээшлүүлсэн бөгөөд монгол хэл, математик, байгалийн ухаан, биеийн тамирын чиглэлээр нэгж хөтөлбөрийн уралдаан зохион байгуулж шилдэг жишиг хөтөлбөрийн санг бүрдүүлэв. 57 тэргүүлэх болон 81 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | залуу багш манлайллын үйл ажиллагаанд хамрагдан туршлага солилцов. Хүртээмжийг нэмэгдүүлэх, удирдлага, албан хаагчдыг дэмжих чиглэлээр 5325 суралцагчид мэргэжлийн чиг баримжаа олгох өдөрлөг зохион байгуулж, хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдад зориулан 39.5 сая төгрөгийн хүртээмжийн орчин бүрдүүлэв. Хувилбарт сургалтын "Гэрт хүрэх багц" төслийн гэрээ байгуулах шатанд орж, эцэг эх, асран хамгаалагчдад хүүхэд хамгаалал, хүмүүжлийн эерэг аргын чиглэлээр олон арга хэмжээ зохион байгуулж 1000 гаруй хүнийг хамруулав. 22 сургуулийн 2303 хүүхдийн үндэсний | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | бичгийн цахим бичвэрийг байршуулж хэрэглээний орчинг бүрдүүлэв. Сурах орчныг сайжруулах, үр ашгийг дээшлүүлэх чиглэлээр ОНХС болон олон улсын байгууллагын санхүүжилтээр нийт 300 гаруй сая төгрөгийн тоног төхөөрөмжийг 15 гаруй сургууль, цэцэрлэгт нийлүүлж, хоол үйлчилгээний стандартыг дээшлүүлэв. Улсын физикийн XXXVII олимпиадыг 200 сая төгрөгийн санхүүжилтээр орон нутагт өндөр түвшинд зохион байгуулж, "Дорнод-Эврика", "Бяцхан шинжлэх ухаанч" зэрэг өдөрлөгүүдэд 3000 гаруй сурагчийг хамруулан шинжлэх ухааны сонирхлыг нэмэгдүүлэв. | |

**Эх сурвалж:** *А.Мөнхжаргал /Статистикийн мэдээлэл, хяналт, шинжилгээ үнэлгээ хариуцсан ахлах арга зүйч/*
*Дорнод аймгийн Боловсролын газар, Бодлогын хэрэгжилтийн хэлтэс, 304 тоот, Емэйл: munkhjargal6lgv@moes.edu.mn Утас: 89336089*

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Хүрсэн түвшин: 100<br>Хавсралт: 3 файл | |
| 1.2. | Суралцагчдад ээлтэй сургалтын орчныг бүрдүүлж, хүртээмжийг нэмэгдүүлэх | 21.2 тэрбум Улс, аймгийн төсөв | Хэрэгжилтийн хувь | 100 | 100 | Зорилтын хүрээнд 10 арга хэмжээг, үүнээс эхний хагас жилд 5 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөн, хэрэгжилтийг 100 хувь ханган ажиллалаа. | 100% |
| 1.2.2 | ЕБС-ийн дотуур байрны хүртээмжийг нэмэгдүүлэх, хүүхдийн сурч, амьдрах орчин нөхцөлийг сайжруулах арга хэмжээ хэрэгжүүлнэ. | 2.9 тэрбум | Нэмэгдсэн суудал/ орны тоо Стандарт, техникийн зохицуулалтын шаардлага хангасан дотуур байрны эзлэх хувь | Нэмэгдсэн суудал/ орны тоо - 0 Стандарт, техникийн зохицуулалтын шаардлага хангасан дотуур байрны эзлэх хувь - 62.5 | Эхний хагас жилд: -<br>Жилийн эцэст: Нэмэгдсэн суудал/ орны тоо - 160 Стандарт, техникийн зохицуулалтын шаардлага хангасан дотуур байрны эзлэх хувь - 68.7 | Дотуур байрны 2 барилга ашиглалтад орох бөгөөд Баян-Уул сумын ерөнхий боловсролын сургуулийн 160 ортой дотуур байрны барилга 86% гүйцэтгэлтэй, гадна шугам сүлжээний ажлын төсөв батлагдаагүйгээс удаашралтай байгаа бөгөөд Боловсролын яаманд санал хүргүүлснээр барилгын гадна шугам сүлжээний ажлыг Эрдэнэт үйлдвэрийн санхүүжилтээр | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | шийдвэрлэхээр судалгаа хийгдэж байна. Цагаан овоо сумын ерөнхий боловсролын сургуулийн 160 ортой дотуур байрны барилгын ажлын гүйцэтгэл 90 хувийн гүйцэтгэлтэй, тус сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар 413.2 сая төгрөгийг баталсан бөгөөд үлдэгдэл ажлыг хийж гүйцэтгэх компанийг сонгон шалгаруулаад байна. Дээрхи дотуур байрууд ашиглалтад орсноор орны тоо 320-оор нэмэгдэж, стандартын шаардлага хангасан дотуур байрны эзлэх хувь 75.0-д хүрнэ. Булган сумын ерөнхий боловсролын сургуулийн 80 ортой дотуур байрын барилгын ажил аймагт эрх шилжиж, Худалдан авах | |

**Эх сурвалж:** А.Мөнхжаргал /Статистикийн мэдээлэл, хяналт, шинжилгээ үнэлгээ хариуцсан ахлах арга зүйч/
Дорнод аймгийн Боловсролын газар, Бодлогын хэрэгжилтийн хэлтэс, 304 тоот, Емэйл: munkhjargal6lgv@moes.edu.mn Утас: 89336089

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ажиллагааны газарт тендер зарлагдаж, гүйцэтгэгч компанитэй гэрээ байгуулах шатанд явж байна. Хүүхдийн амьдрах орчин нөхцөлийг сайжруулах чиглэлээр аймгийн төсвийн 252.6 сая төгрөгөөр Булган сумын ерөнхий боловсролын дотуур байрны халаалтын шугамыг засварлаж, Халхгол сумын Ялалт багийн ерөнхий боловсролын сургууль аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн 50.2 сая төгрөгийн гал тогооны тоног төхөөрөмж нийлүүлсэн.<br>Хүрсэн түвшин: Стандарт, техникийн зохицуулалтын шаардлага хангасан дотуур байрны эзлэх хувь - 62.5<br>Хавсралт: 3 файл | |
| 1.2.4 | Хүүхдүүдийн | 3.3 тэрбум | Тендер | Тендер | Эхний хагас жилд: | Аймгийн орон | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | цэцэрлэг, сургуульдаа хэвийн нөхцөлд суралцаж, хөгжих орчин нөхцөлийг сайжруулна. | | зарлуулсан тоо Төсөл арга хэмжээний тоо | зарлуулсан тоо - 14 Хэрэгжсэн төсөл арга хэмжээний тоо - 16 | Тендер зарлуулсан тоо - 14 Жилийн эцэст: Хэрэгжсэн төсөл арга хэмжээний тоо - 16 | нутгийн төсөв болон Орон нутгийн хөгжлийн сангийн (ОХС) 2.6 тэрбум төгрөгийн хөрөнгөөр боловсролын салбарт нийт 19 төсөл, арга хэмжээг батлан хэрэгжүүлж байгаагаас өнөөдрийн байдлаар 8 нь бүрэн дуусаж, 11 нь хэрэгжилтийн шатанд үргэлжилж байна. Үүнд, сургалтын орчны хүртээмж, аюулгүй байдлыг хангах 3 сургуульд 917.7 сая төгрөгийн спорт заал, ариун цэврийн байгууламж, гадаа спорт талбай байгуулах, 528.5 сая төгрөгийн өртөгтэй 2 цэцэрлэг, 1 сургуулийн их засвар, мөн инженерийн дэд бүтцийг сайжруулах 711.8 сая төгрөгийн төсөвтэй 2 цэцэрлэг, 2 сургууль, 1 дотуур байрны дулаан | |

***Эх сурвалж:*** *А.Мөнхжаргал /Статистикийн мэдээлэл, хяналт, шинжилгээ үнэлгээ хариуцсан ахлах арга зүйч/*
*Дорнод аймгийн Боловсролын газар, Бодлогын хэрэгжилтийн хэлтэс, 304 тоот, Емэйл: munkhjargal6lgv@moes.edu.mn Утас: 89336089*

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хангамжийн засварын ажлууд гэрээний дагуу хийгдэж байна. Түүнчлэн техник хангамжийг сайжруулах 471.0 сая төгрөгийн өртөг бүхий 8 төсөл бүрэн хэрэгжиж, 2 сургуульд "Цахим анги", 2 сургуульд урлаг, гоо зүйн танхим, 1 сургуульд физикийн кабинет, 23 сургуульд физикийн кабинетийн тоног төхөөрөмж, хэрэглэгдэхүүн, 2 сургуульд радио нэвтрүүлгийн өрөөний тоног төхөөрөмжийг тус тус нийлүүлсэн байна. Мөн 7 сургуулийн тусгай хэрэгцээт ариун цэврийн өрөөний материал, 7 цэцэрлэг, 9 сургууль, дотуур байрны хоол үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийг хүлээлгэн өгсөн бөгөөд хөгжлийн | |

**Эх сурвалж:** А.Мөнхжаргал /Статистикийн мэдээлэл, хяналт, шинжилгээ үнэлгээ хариуцсан ахлах арга зүйч/
Дорнод аймгийн Боловсролын газар, Бодлогын хэрэгжилтийн хэлтэс, 304 тоот, Емэйл: munkhjargal6lgv@moes.edu.mn Утас: 89336089

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийг дэмжих “Гэрт хүргэх багц” сургалтын материалыг хүлээн авах комисс ажиллаж байна.<br>Хүрсэн түвшин: 19<br>Хавсралт: 2 файл | |
| 1.2.5 | Сурах бичгийн хангалтын хувийг нэмэгдүүлнэ. | Зохион байгуулалтын арга хэмжээ | Сурах бичиг хангалтын хувь | 90.2 | Эхний хагас жилд: 90.2<br>Жилийн эцэст: 92.0 | Ерөнхий боловсролын сургуулийн 1-5 дугаар ангийн сурах бичгийн хангалт 100 хувь, дунд ахлах ангийн суралцагчдын 80 хувь нь сургуулийн номын сангаар дамжуулан төлбөртэй сурах бичиг ашиглаж байгаа ба 10-15 хувь нь өөрийн хүсэлтээр худалдан авч ашиглаж байна. Сурах бичгийн хангалт 94 хувьд хүрсэн.<br>Хүрсэн түвшин: 94.0<br>Хавсралт: 1 файл | 100% |
| 1.2.6 | Ерөнхий боловсролын | Зохион байгуулалтын | Сургалт, нөлөөллийн | 11 | Эхний хагас жилд: 4 | Ерөнхий боловсролын | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | сургууль, цэцэрлэгийн хүний нөөцийг бэлтгэх, чадавхжуулах, хоол хүнсний үйлчилгээнд оролцогч талуудад хоол, шим тэжээлийн боловсрол олгох, олон нийтэд сурталчлан таниулах ажлыг зохион байгуулна. | арга хэмжээ | ажлын тоо | | Жилийн эцэст: 6 | сургууль, цэцэрлэгийн хоол үйлдвэрлэлийн хүний нөөцийг бэлтгэх, чадавхжуулах чиглэлээр “Хоол үйлдвэрлэлийн бэлэн байдал ба эрүүл ахуй” сэдэвт сургалтыг 7 багц сэдвээр зохион байгуулан, 118 тогооч, хоол зүйчийг хамруулжээ. Нийт 7 удаагийн сургалт, нөлөөллийн ажлаар 208 ажилтанд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн нь үйлчилгээний чанарыг сайжруулах, стандартыг мөрдүүлэхэд бодит ахиц гарсан.<br>Хүрсэн түвшин: 7<br>Хавсралт: 4 файл | |
| 1.2.7 | Цэцэрлэг сургуулийн суралцагчдын эрүүл мэндийг дэмжсэн “Өдөр бүр нэг аяга сүү” хөтөлбөрийг орон | Зохион байгуулалтын арга хэмжээ | Хэрэгжүүлсэн СӨБ, ЕБС-ийн тоо | СӨБ-31, ЕБС-22 | Эхний хагас жилд: СӨБ-31, ЕБС-22 Жилийн эцэст: СӨБ-31, ЕБС-22 | Хүүхдийн эрүүл мэнд, өсөлт хөгжлийг дэмжих “Өдөр-бүр 1 аяга сүү” арга хэмжээг 31 цэцэрлэг орон нутаг, хүүхдийн | 100% |

***Эх сурвалж:*** *А.Мөнхжаргал /Статистикийн мэдээлэл, хяналт, шинжилгээ үнэлгээ хариуцсан ахлах арга зүйч/*
*Дорнод аймгийн Боловсролын газар, Бодлогын хэрэгжилтийн хэлтэс, 304 тоот, Емэйл: munkhjargal6lgv@moes.edu.mn Утас: 89336089*

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | нутаг болон эцэг эхийн оролцоотойгоор төсөв санхүүжилтийг шийдвэрлэн зохион байгуулна. | | | | | хоолны түүхий эдийн зардал болон эцэг эхийн оролцоо дэмжлэгээр нийт 119 сая төгрөгийг зарцуулан, 7 хоногийн 2-5 өдөрт хэрэгжүүлэн нийт 5817 хүүхдийг, төрийн өмчийн 22 сургууль орон нутаг, хүүхдийн хоолны түүхий эдийн зардал болон эцэг эх, асран хамгаалагчдын оролцоо дэмжлэгээр нийт 174.0 сая төгрөгийг зарцуулан, 7 хоногийн 1-5 өдөрт хэрэгжүүлж нийт 9298 суралцагчийг хамруулан, санхүүжилтийг шийдвэрлэн, хэрэгжилтийг ханган ажиллав.<br>Хүрсэн түвшин: СӨБ-31, ЕБС-22<br>Хавсралт: 3 файл | |
| Гурав. Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ | | | | | | | |
| 3.1. | Хүүхдийн хөгжил, авьяас, ур чадвар, техник сэтгэлгээ, | 595.2 сая | Төлөвлөсөн арга хэмжээнүүдийн хэрэгжилтийн | 100 | 100 | Зорилтын хүрээнд 12 арга хэмжээ, үүнээс эхний хагас | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | төлөвшлийг дэмжихэд эцэг эх, олон нийтийн оролцоог нэмэгдүүлж, хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлнэ. | | хувиар | | | жилдс11 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөн 10 арга 100 хувь, 1 арга хэмжээг 70 хувийн гүйцэтгэлтэйгээр, нийт хэрэгжилтийг 97.2 хувьд хүргэн ажиллалаа. | |
| 3.1.1 | Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгүүд хүүхдэд уламжлалт зан заншил, өв соёл, эх түүхээрээ бахархдаг, эх оронч сэтгэлгээтэй, өөрийн гэсэн үнэт зүйлтэй болох төлөвшил, хөгжлийг дэмжсэн сургалт, нөлөөллийн үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. | Зохион байгуулалтын арга хэмжээ | Хэрэгжилтийн хувиар | 100 | Эхний хагас жилд: 100<br>Жилийн эцэст: 100 | Хүүхэд, багачуудад үндэстний дархлаа төлөвшүүлэх, уламжлалт зан заншил, өв соёлыг өвлүүлэх сургалт, нөлөөллийн ажлуудыг зохион байгууллаа. "Монгол ахуй" өдөрлөгөөр 7 сургууль, 12 цэцэрлэгийн 478 суралцагчид нүүдэлчин ахуйг таниулж, уламжлалт наадгайн тэмцээнд 3 сургууль, 16 цэцэрлэгийн 341 хүүхдийг хамруулан гарын жижиг булчин, логик сэтгэхүйг нь дэмжлээ. "Үндэсний хувцасны өдөр"-ийг 26 сургууль, 32 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | цэцэрлэг тогтмолжуулснаар суралцагчид үндэсний үнэт зүйлийг биечлэн мэдрэх суурь нөхцөлийг бүрдүүлэв. Сургуулийн өмнөх боловсролын 21 байгууллага 2500 хүүхдийг ардын аман зохиолоор дамжуулан хэл яриаг, уламжлалт наадгай, "Өв соёлын өргөө" булангаар дамжуулан өв соёлоо бага наснаас нь мэдрэх нөхцөлийг бий болголоо. Ерөнхий боловсролын сургуулийн монгол хэл, үндэсний бичиг, түүх, соёлын хичээлийн чанарыг сайжруулахад анхаарч, түүхэн үйл явдлыг аялгуулан унших, дүрд тоглох, кино хэлэлцүүлэг өрнүүлэх бүтээлч аргаар уран зохиол, хөгжим, дүрслэх урлагийн | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хичээлүүдийн интеграцилан зохион байгуулсанаар суралцагчдад монгол ахуй, уламжлалт зан заншлыг цогцоор нь ойлгох нөхцөлийг бүрдүүллээ. Мөн "Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III"-ийг хэрэгжүүлж, сурагчдын үндэсний бичгээр унших, бичих, шивэх чадварыг нэмэгдүүлэн, сургуулийн орчныг хос бичгээр хаягжуулав. Эдгээр үйл ажиллагаанд 2840 суралцагч хамрагдаж соёлын өвийг тээгч болох суурь тавигдсан байна. "Үндэсний бичиг-Өрх бүрд" сарын аянд 22 сургуулийн 2303 хүүхэд цахим бичвэрээ албан ёсны хуудсуудад байршуулж, "Үндэсний бичгийн олимпиад"-д 6 сумын 200 гаруй | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хүүхэд бичгийн болон бийрийн төрлөөр ур чадвараа уралдуулан сорьсон. Чөлөөлөх дайны ялалтын 80 жилийн ойн хүрээнд "Эх оронч Монголчууд" сэдэвт хичээлийг 26 сургуулийн 54 багш, цэргийн хэлтсийн 14 албан хаагчтай хамтран зааж, 2264 сурагчийг хамрууллаа. Мөн Их Монгол улс байгуулагдсаны 820 жилийн ойн хүрээнд "Туг Чингисийн сүмийн түүхийг тодруулахуй" хэлэлцүүлэгт 75 суралцагч, "Монгол цэрэг энхийг сахиулах үйлсэд" сургалтад 10-12 дугаар ангийн 540 сурагч тус тус хамрагдлаа.<br>Хүрсэн түвшин: 100<br>Хавсралт: 2 файл | |
| 3.1.2 | Хичээлээс гадуурх сургалтын ажлыг | 510 сая | Хэрэгжилтийн хувь | 100 | Эхний хагас жилд: 100 | Ерөнхий боловсролын 27 | 100% |

**Эх сурвалж:** А.Мөнхжаргал /Статистикийн мэдээлэл, хяналт, шинжилгээ үнэлгээ хариуцсан ахлах арга зүйч/
Дорнод аймгийн Боловсролын газар, Бодлогын хэрэгжилтийн хэлтэс, 304 тоот, Емэйл: munkhjargal6lgv@moes.edu.mn Утас: 89336089

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | дэмжих, хүүхдийн оролцоо хэрэгцээнд суурилсан секц, дугуйлангийн нэр төрлийг нэмэгдүүлж, цахим, танхим хосолсон олон талт хэлбэрээр мэргэжлийн байгууллага, мэргэшсэн иргэнтэй хамтарч зохион байгуулах, үр дүнг тооцон ажиллана. /Хүн болох багаасаа "Гадаад хэлний сургалтын төсөл хэрэгжүүлнэ/ | | | | Жилийн эцэст: 100 | сургуульд сагсан бөмбөг, волейбол, шатар, ширээний теннис, хөлбөмбөг, хөнгөн атлетик, жүдо, үндэсний бөх, үндэсний сур, бадминтон зэрэг спортын 110 секцэд 3750 суралцагч, хөгжим, найрал дуу, үкүлэлэ, морин хуур, бүжиг зэрэг урлагийн 70 дугуйланд 1973 суралцагч, нисэх загвар, усан загвар, робот, дизайн технологи зэрэг урлан бүтээх 28 дугуйланд 735 суралцагч, шатар, даам сэтгэн бодох зэрэг хөгжүүлэх бусад 67 дугуйланд 3347 суралцагч, нийт 275 төрлийн секц, дугуйланд 9805 суралцагч хамрагдаж байна. Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн 1.6 тэрбум төгрөгийн санхүүжилтээр секц, дугуйлангийн нэр төрлийг олшруулах, | |

***Эх сурвалж:*** *А.Мөнхжаргал /Статистикийн мэдээлэл, хяналт, шинжилгээ үнэлгээ хариуцсан ахлах арга зүйч/*
*Дорнод аймгийн Боловсролын газар, Бодлогын хэрэгжилтийн хэлтэс, 304 тоот, Емэйл: munkhjargal6lgv@moes.edu.mn Утас: 89336089*

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | мэргэжлийн байгууллага болон мэргэшсэн байгууллага, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилготой “Хүн болох багаасаа” төслийг амжилттай хэрэгжүүлж байна. Үүнд, Биеийн тамир, спортын газраас 15 төрлийн 29 багц секц, дугуйланд 2500 суралцагчийг, Гэр бүл, хүүхэд хөгжлийн газраас авьяасыг дэмжих 6 төрлийн 31 багц сургалтад 2818 суралцагчийг, Боловсролын газраас гадаад хэлний 3 төрлийн 21 багц сургалтад 2200 суралцагчийг тус тус хамруулан зохион байгуулж байна. Төслийн хүрээнд нийт 87 багц тендер шалгарч, аймгийн 23 сургуулийн 6-14 насны сурагчид спорт, урлаг, оюун ухаан болон гадаад хэлний 40-60 цагийн | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хөтөлбөрт суралцсан байна. Эдгээр сургалтыг мэргэжлийн 219 гаруй багш, дасгалжуулагчид чиглүүлэн ажиллаж, хүүхэд залуучуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, авьяас чадварыг нь нээж хөгжүүлэх нөхцөлийг бүрдүүллээ.<br>Хүрсэн түвшин: 100<br>Хавсралт: 4 файл | |
| 3.1.3 | Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн өөрийн удирдлагын байгууллага, хүүхэд бүрийн хөгжил, хамтын оролцоог дэмжсэн клуб, дугуйлангийн үйл ажиллагааг дэмжих, энэ чиглэлээр суралцагч, багш нарын ур чадварыг нэмэгдүүлэх | Зохион байгуулалтын арга хэмжээ | Суралцагчийн өөрийн удирдлагын байгууллагуудад хамрагдсан суралцагчийн тоо Зохион байгуулсан арга хэмжээ | Хамрагдсан суралцагчийн тоо 2496 Зохион байгуулсан арга хэмжээ 59 | Эхний хагас жилд: 2496 / 20 Жилийн эцэст: 2300 / 60 | Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдын өөрийн удирдлагын байгууллага, хүүхэд бүрийн хөгжил, хамтын оролцоог дэмжих чиглэлээр аймгийн хэмжээний 26 сургуульд Сурагчдын зөвлөл, Өсвөрийн эмч, Үе тэнгийн сургагч багш, Эрүүл Монгол хүн, Эко клуб зэрэг суралцагчдын өөрийн удирдлагын | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | ажлыг зохион байгуулна. | | | | | 13 төрлийн байгууллага, клуб тогтмол үйл ажиллагаа явуулж, нийт 2,665 суралцагчийг хамруулан ажиллаж байна. Суралцагчдын хөгжих, оролцох эрхийг хангах хүрээнд нийт 22 төрлийн арга хэмжээг санаачлан зохион байгуулж, давхардсан тоогоор 25,611 суралцагчийг хамруулсны зэрэгцээ өсвөрийн улаан загалмайн 300 сурагчийн дунд “Хүмүүнлэгийн хүчээ нэгтгэе” чуулга уулзалт, хүүхэд залууст эх оронч үзэл, хүмүүжил төлөвшүүлэх зорилготой уламжлалт “Цэрэг-спортын Дөл-2026” цогцолбор тэмцээнийг Хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх үндэсний | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хөтөлбөр"-ийн хүрээнд зохион байгуулагдсан тэмцээнд аймгийн төв болон сумдын 11 сургуулийн 132 сурагч оролцож, хурд хүч, авхаалж самбаа, тэсвэр хатуужлаа сорин өрсөлдөх ажлыг амжилттай зохион байгууллаа. Хүрсэн түвшин: Хамрагдсан суралцагчийн тоо 2665, Зохион байгуулсан арга хэмжээ 22 Хавсралт: 3 файл | |
| 3.1.4 | Элсэлтийн шалгалтын эрчимжүүлсэн сургалт зохион байгуулж, амжилт үзүүлсэн багш, суралцагч, сургалтын байгууллагыг урамшуулна. | 50.2 сая | Хэрэгжилтийн хувиар | 100 | Эхний хагас жилд: 100 Жилийн эцэст: 100 | Боловсролын газраас 2026 оны хагас жилийн байдлаар 12-р ангийн суралцагчдад зориулан 5 удаагийн онлайн сорилыг тогтмол зохион байгуулсан. "Дорнод ЭШ-2026" бүлгэмд 10 үндсэн судлагдахуунаар бичлэгээр 24, файлаар /word | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | болон pdf/ 7 удаагийн нийт 31 удаагийн мэргэжлийн тайлбар, зөвлөмжийг бүлгэмээр дамжуулан хүргэж, суралцагчдын өөрийгөө үнэлэх боломжийг бүрдүүлж, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн. Багш, суралцагчид үр дүнд хамтарсан анализ хийж, шалгалтын бэлтгэлийг бодит өгөгдөлд тулгуурлан эрчимжүүлж эргэх холбоотой ажиллаж байна.<br>Хүрсэн түвшин: 100<br>Хавсралт: 3 файл | |
| 3.1.5 | Ахлах ангийн суралцагчдыг цахим сургалтын системээр сонгон суралцах боломжийг бүрдүүлэх, цахим сургуульд сонгон судлах хичээлээр | Зохион байгуулалтын арга хэмжээ | Ирц, хамрагдалтын хувь | 75 | Эхний хагас жилд: 80<br>Жилийн эцэст: 82 | 2025-2026 оны хичээлийн жилд Дорнод аймгийн ерөнхий боловсролын 15 сургуулийн ахлах ангийн давхардсан тоогоор 434 суралцагч цахим | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | судалж буй ахлах ангийн суралцагчдын ирц, хамрагдалтыг сайжруулахад дэмжлэг үзүүлнэ. | | | | | сургуулийн сонгон судлах хичээлд хамрагдаж байна. Сургалтын үйл ажиллагааг эрчимжүүлэх хүрээнд сургуулиудын удирдлагын багт цахим орчинд ажиллах, сурагчдыг идэвхжүүлэх чиглэлээр нийт 6 удаагийн зааварчилгаа, зөвлөмжийг хүргэж ажиллалаа. Аймгийн хэмжээнд цахим сургалтын ирц 4 дүгээр сарын 1-ний байдлаар 46.8 хувьд хүрч, 1 дүгээр сараас 10.4 хувиар ахисан үзүүлэлттэй байсан бөгөөд ирцийн бүтцийг шинжлэхэд нийт суралцагчдын дунд хичээл таслалт болон идэвхгүй байдал давамгайлж байгаа нь сургалтын хамрагдалтад сөргөөр нөлөөлөх гол хүчин зүйл болж байгааг анхаарч, | |

***Эх сурвалж:*** *А.Мөнхжаргал /Статистикийн мэдээлэл, хяналт, шинжилгээ үнэлгээ хариуцсан ахлах арга зүйч/*
*Дорнод аймгийн Боловсролын газар, Бодлогын хэрэгжилтийн хэлтэс, 304 тоот, Емэйл: munkhjargal6lgv@moes.edu.mn Утас: 89336089*

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хичээл тасалсан суралцагчдад агуулгыг нөхөн үзүүлж, бие даах даалгаврыг гүйцэтгүүлэн, ирцийг нөхөн тооцуулах уян хатан зохицуулалтуудыг 15 сургуульд хэрэгжүүллээ. Нөхөн гүйцэтгэж, хичээлдээ суралцагчид хамрагдсанаар цахим ангийн ирц энэ хичээлийн жилд 80-аас дээш хувьтай дүгнэгдсэн. Сургууль бүрээр цахим сургуульд сонгон судлах хичээлээр судалж буй ахлах ангийн суралцагчдын ирц, хамрагдалтад үнэлгээ хийхэд ирцийг нэмэгдүүлэх чиглэлээр санаачилгатай ажилласан байна.<br>Хүрсэн түвшин: 80<br>Хавсралт: 1 файл | |
| 3.1.6 | Байгалийн ухааны туршилтын багаж, | 35.0 сая Аймгийн Орон | Туршилтын багаж хэрэглэгдэхүүнийг | Туршилтын багаж хэрэглэгдэхүүнийг | Эхний хагас жилд: -- | Дорнод аймгийн Засаг даргын А/72-р | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хэрэглэгдэхүүний хангалтыг нэмэгдүүлэх, суралцагчдын судлан шинжлэх, арга барилыг дэмжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлнэ. | нутгийн хөгжлийн сан | нэмэгдүүлсэн сургуулийн тоо Судлан шинжлэх чадвараа хөгжүүлсэн суралцагчийн тоо | нэмэгдүүлсэн сургууль -2 Судлан шинжлэх чадвараа хөгжүүлсэн суралцагч - 3260 | Жилийн эцэст: Туршилтын багаж хэрэглэгдэхүүнийг нэмэгдүүлсэн сургууль -1 Судлан шинжлэх чадвараа хөгжүүлсэн суралцагч - 3400 | захирамжаар хичээлээс гадуурх үйл ажиллагааны хүрээнд хүүхдийн авьяас чадварыг нээн илрүүлэх, сонирхолд нь тулгуурлан хөгжүүлэх замаар шинжлэх ухаанч техник сэтгэлгээтэй, бүтээлч иргэнийг төлөвшүүлэх зорилгоор дараах үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүллээ. Үүнд: Суралцагчдын сорил туршилт, судалгаа шинжилгээ хийх чадварыг дээшлүүлэх шинжлэх ухааны туршилт бүхий оюуны бүтээлүүдийг урамшуулах, сурталчлах зорилго бүхий "Гэртээ туршья" аянд Ерөнхий боловсролын 20 сургуулийн 2-11 дүгээр ангийн 1705 туршилтат контентийг 1860 хүүхэд хамтран | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хийж, “Дорнод Эврика” фэйж хуудсанд байршуулж, 1190 хүн сэтгэгдэл үлдээж, 14597 хүн контентод хариу үйлдэл үзүүлж, 171701 хүн үзэж сонирхсон ба 2025 онтой харьцуулахад туршилтын контентын тоо 364-аар нэмэгдсэн байна. Суралцагчийн шинжлэн судлах чадварыг дэмжих туршилтат олимпиадад 23 сургуулийн 64 багийн 200 суралцагч оролцсон ба өмнөх онтой харьцуулахад хүүхдийн тоо 30-аар нэмэгдсэн үр дүн харагдаж байна. Физик, хими, газарзүй, биологийн дугуйланд 800 гаруй суралцагч хамрагдан суралцсан бөгөөд “Эврика” бүтээлийн уралдаанд 4 төрлөөр 23 | |

***Эх сурвалж:*** *А.Мөнхжаргал /Статистикийн мэдээлэл, хяналт, шинжилгээ үнэлгээ хариуцсан ахлах арга зүйч/*
*Дорнод аймгийн Боловсролын газар, Бодлогын хэрэгжилтийн хэлтэс, 304 тоот, Емэйл: munkhjargal6lgv@moes.edu.mn Утас: 89336089*

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | сургуулийн 4 судлагдахууны 55 мэргэжлийн багш оролцож, химийн хичээлийн 20, физикийн хичээлийн 11, Биологийн хичээлийн 15, газарзүйн хичээлийн 10 дугуйлангийн 600 суралцагчийн нийт 120 гаруй бүтээл танилцуулагдсан ба өмнөх онтой харьцуулахад бүтээлийн тоо 24-ээр нэмэгдсэн байна. Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 25 сая төгрөгийн байгалийн ухааны кабинетийн тоног төхөөрөмжийг Хэрлэн сумын 8-р сургуульд нийлүүлж, туршилтын багаж, хэрэглэгдэхүүний хүртээмжийг нэмэгдүүллээ.<br>Хүрсэн түвшин: Туршилтын багаж хэрэглэгдэхүүнийг | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | нэмэгдүүлсэн сургууль -2 Судлан шинжлэх чадвараа хөгжүүлсэн суралцагч - 2860<br><br>Хавсралт: 1 файл | |
| 3.1.7 | Сургуулийн өмнөх насны хүүхдийн хөгжил, хамгаалал болон сургуульд бэлтгэгдсэн байдлын үнэлгээ, ерөнхий боловсролын сургуулийн сурагчдаас авах улсын шалгалт, чанар болон гүйцэтгэлийн үнэлгээ, ерөнхий боловсролын сургууль төгсөгч, их, дээд сургууль, коллежид элсэгчдээс авах монгол хэл, бичиг, элсэлтийн шалгалтыг чанартай зохион байгуулахад дэмжлэг үзүүлэн ажиллана. | Зохион байгуулалтын арга хэмжээ | Хэрэгжилтийн хувь | 100 | Эхний хагас жилд: 100<br>Жилийн эцэст: 100 | Хүүхдийн хөгжлийн үнэлгээ болон бүх шатны сургалтын чанар, гүйцэтгэлийн шалгалтыг чанартай зохион байгуулах зорилтын хүрээнд дараах ажлуудыг хэрэгжүүллээ. Боловсролын сайдын 2026 оны 3 дугаар сарын 11-ний өдрийн А/79 дүгээр тушаалаар “Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамрагдаж байгаа суралцагчийн хөгжил болон сургуульд бэлтгэгдсэн байдлыг үнэлэх журам” батлагдаж, сургуульд бэлтгэгдсэн байдлын үнэлгээг зохион байгуулах | 100% |

***Эх сурвалж:*** *А.Мөнхжаргал /Статистикийн мэдээлэл, хяналт, шинжилгээ үнэлгээ хариуцсан ахлах арга зүйч/*
*Дорнод аймгийн Боловсролын газар, Бодлогын хэрэгжилтийн хэлтэс, 304 тоот, Емэйл: munkhjargal6lgv@moes.edu.mn Утас: 89336089*

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | бэлтгэл хангаж ажиллаж байна. Хичээлийн жилд 1–12 дугаар ангийн сурагчдаас 63 удаагийн хөндлөнгийн шалгалт зохион байгуулж, сайжруулсан хөтөлбөрийн хэрэгжилт болон 19251 суралцагчдын мэдлэгийн хэрэглээ, хувирган ашиглах чадварт дүн шинжилгээ хийв. Анги дэвших шалгалтын 3-11 дүгээр ангийн 18 судлагдахууны 85 дэлгэрэнгүй блюпринтийг боловсруулж, сургуулиудад хүргэн ажиллалаа. Элсэлтийн шалгалтын эрх авах Монгол хэл, бичгийн шалгалтад 12 дугаар ангийн 478, 11 дүгээр ангийн 930, 10 дугаар ангийн 870, нийт 2,278 суралцагч хамрагдсанаас 7 | |

***Эх сурвалж:*** *А.Мөнхжаргал /Статистикийн мэдээлэл, хяналт, шинжилгээ үнэлгээ хариуцсан ахлах арга зүйч/*
*Дорнод аймгийн Боловсролын газар, Бодлогын хэрэгжилтийн хэлтэс, 304 тоот, Емэйл: munkhjargal6lgv@moes.edu.mn Утас: 89336089*

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | суралцагч 800 оноотой дүгнэгдсэн ба аймгийн хэмжээнд нийт гүйцэтгэл 530.5 онооны дундажтай дүгнэгдсэн байна. СӨБ-ын байгууллагын болон багшийн гүйцэтгэлийн үнэлгээ зохион байгуулагдах бэлтгэл ажлын хүрээнд unelgee.eec.mn системд суурь мэдээллийг үнэн зөв бүрдүүлж, 31 цэцэрлэгийн 226 багш үнэлгээнд оролцож, суурь дата мэдээллийг баталгаажуулсан. “Ерөнхий боловсролын сургалтын байгууллага, багшийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээг сургуулийн түвшинд зохион байгуулах удирдамж”-ийн дагуу ерөнхий боловсролын 23 сургуулийн цахим | |

**Эх сурвалж:** А.Мөнхжаргал /Статистикийн мэдээлэл, хяналт, шинжилгээ үнэлгээ хариуцсан ахлах арга зүйч/
Дорнод аймгийн Боловсролын газар, Бодлогын хэрэгжилтийн хэлтэс, 304 тоот, Емэйл: munkhjargal6lgv@moes.edu.mn Утас: 89336089

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 438 шалгалтад 13890 суралцагч, цаасан суурьтай 214 шалгалтад 5694 суралцагчийн мэдээлэл гүйцэтгэлийн үнэлгээнд хамрагдсан бөгөөд зохион байгуулалтыг удирдлагаар хангаж ажиллалаа.<br>Хүрсэн түвшин: 100<br>Хавсралт: 4 файл | |
| 3.1.9 | Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоонд суралцагчийг тодорхой насны давтамжтай хамруулах үйл ажиллагааг зохион байгуулах; | Зохион байгуулалтын арга хэмжээ | Хэрэгжилтийн хувь | 90.2 | Эхний хагас жилд: 100<br>Жилийн эцэст: 100 | Улаан бурхны өвчлөлттэй холбогдуулан аймгийн ерөнхий боловсролын сургуулийн зорилтот 10-15 насны суралцагчдыг улаанбурхны нэмэлт дархлаажуулалтад хамруулах ажлыг эрүүл мэндийн байгууллагатай хамтран зохион байгуулсан. Дархлаажуулалтад хамрагдвал зохих нийт 7770 сурагчаас 6152 суралцагч 79.2 | 70% |

**Эх сурвалж:** *А.Мөнхжаргал /Статистикийн мэдээлэл, хяналт, шинжилгээ үнэлгээ хариуцсан ахлах арга зүйч/*
*Дорнод аймгийн Боловсролын газар, Бодлогын хэрэгжилтийн хэлтэс, 304 тоот, Емэйл: munkhjargal6lgv@moes.edu.mn Утас: 89336089*

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хувийг хамруулсан. Хүрсэн түвшин: 70% Хавсралт: 1 файл | |
| 3.1.10 | Эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, гэр бүл, иргэдэд чиглэсэн сургалт, нөлөөллийн үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. | Зохион байгуулалтын арга хэмжээ | Хэрэгжилтийн хувиар | 100 | Эхний хагас жилд: 100 Жилийн эцэст: 100 | Байгууллагын үйл ажиллагааны хүрээнд сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, хүүхэд хамгааллын үйлчилгээг сайжруулах, эцэг эх, багш нарыг чадавхжуулах чиглэлээр дараах ажлуудыг үе шаттайгаар зохион байгуулж, үр дүнг тооцон ажиллалаа. Сургуулийн өмнөх боловсролын 32 байгууллагын 6498 эцэг эх, асран хамгаалагчдыг сургалт, нөлөөллийн ажилд хамруулж, цэцэрлэгийн насны 233 хүүхдийн гэрээр айлчлан боловсролын үйлчилгээг гэр бүлийн орчинд нь | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | үзүүллээ. Мөн Дорнод аймгийн Ерөнхий боловсролын 26 сургуулийн 10733 эцэг эхийг хамруулан Боловсролын тухай болон Хүүхэд хамгааллын тухай хуулийг сурталчлах, хүүхэд хүмүүжлийн зөрөг арга, гэр бүлийн үнэ цэнэ, эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 28 төрлийн сургалт, нөлөөллийн үйл ажиллагааг тогтмол зохион байгууллаа. Эдгээр ажлын үр дүнд эцэг эхчүүдийн хүүхэдтэйгээ зөрөг харилцах ур чадвар дээшилж, хүүхэд хамгааллын хариуцлага, ойлголт нэмэгдсэн байна. Хүүхэд хамгааллын урьдчилан сэргийлэх, хамгаалах, нөхөн сэргээх, шуурхай тусламж үзүүлэх үйлчилгээний | |

**Эх сурвалж:** А.Мөнхжаргал /Статистикийн мэдээлэл, хяналт, шинжилгээ үнэлгээ хариуцсан ахлах арга зүйч/
Дорнод аймгийн Боловсролын газар, Бодлогын хэрэгжилтийн хэлтэс, 304 тоот, Емэйл: munkhjargal6lgv@moes.edu.mn Утас: 89336089

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | чанарыг сайжруулахаар “Хамтдаа-Хөгжье-Оролцъё-Хамгаалъя” нэгдсэн арга хэмжээг зохион байгууллаа. Тус арга хэмжээгээр Хэрлэн сумын цэцэрлэг, сургууль, мэргэжлийн боловсролын байгууллагын 59 өрхийн 56 оролцогчид “Сэтгэл зүйн боловсрол”, “Гэр бүлийн баяр хөөр”, “Хүмүүжлийн зөрэг арга” сургалт явуулж, өрхүүдэд чиглэсэн хүүхэд хамгааллын дэмжлэгийг нэмэгдүүлэв. Түүнчлэн багш нарын хувь хүний хөгжил, мэргэжлийн ур чадварыг дэмжих зорилгоор “Гэр бүлийн бахархал” ТББ-тай хамтран Хэрлэн сумын ерөнхий боловсролын 10 сургуулийн 199 багшийг хамруулсан “Хөгжиж өөрчлөгдөх | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | амжилтын нууц" сэдэвт сургалтыг зохион байгуулж, багш нарын ажиллах урам зоригийг дэмжлээ.<br>Хүрсэн түвшин: 100%<br>Хавсралт: 3 файл | |
| 3.1.11 | Ерөнхий боловсролын сургууль, дотуур байрны орчинд хүүхдийг аливаа хэлбэрийн дарамт, хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах чиглэлээр нөлөөллийн ажлыг олон талт хэлбэрээр зохион байгуулах, зөвлөгөө мэдээлэл авах нээлттэй утас ажиллуулах; | Зохион байгуулалтын арга хэмжээ | Хэрэгжилтийн хувиар | 100 | Эхний хагас жилд: 100<br>Жилийн эцэст: 100 | Дорнод аймгийн Засаг даргын 2025 оны 03 дугаар албан даалгавар болон Хүүхэд хамгааллын тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд дараах олон талт арга хэмжээг зохион байгууллаа.<br>Аймгийн ХГБХХГ болон Дэлхийн зөн Монгол ОУБ-тай хамтран ерөнхий боловсролын 18 сургууль, 4 цэцэрлэгийн 22 мэргэжилтнийг "Гэрээр айлчлал аргачлал"-ын сургагч багшаар бэлтгэж, чадавхжуулав. Энэ хүрээнд "Хамтдаа-Хөгжье-Оролцъё- | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Хамгаалъя” нэгдсэн арга хэмжээг зохион байгуулж, Хэрлэн сумын зорилтот бүлгийн 59 өрхийн 56 иргэн, дотуур байрны 18 багшид “Сэтгэл зүйн боловсрол”, “Хүмүүжлийн зерэг арга” сэдэвт арга зүйн дэмжлэг үзүүлэв. Гэрээр айлчлах арга хэмжээгээр дамжуулан суралцагчдын аюулгүй байдал, эрсдэлийг тандаж, хамгаалал шаардлагатай хүүхдүүдийг Хамтарсан багийн шуурхай тусламж, үйлчилгээнд холбон зуучиллаа. Аюулгүй орчин бүрдүүлэх чиглэлээр Цагдаагийн газар, Хүний эрхийн комиссын саналыг үндэслэн “Хяналтын камер ашиглах журам”-ыг шинээр боловсруулан гаргаж, 76 боловсролын | |

***Эх сурвалж:*** *А.Мөнхжаргал /Статистикийн мэдээлэл, хяналт, шинжилгээ үнэлгээ хариуцсан ахлах арга зүйч/*
*Дорнод аймгийн Боловсролын газар, Бодлогын хэрэгжилтийн хэлтэс, 304 тоот, Емэйл: munkhjargal6lgv@moes.edu.mn Утас: 89336089*

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байгууллагад хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Хүүхдийг аливаа эрсдэлээс хамгаалах “Итгэлтэй утас” үйлчилгээг ерөнхий боловсролын сургуулиудын 65.3 хувь, дотуур байрны 75 хувьд байршуулснаар сурагчид асран хамгаалагчтайгаа үнэ төлбөргүй холбогдох боломж бүрдэв. Сэтгэл зүйн үйлчилгээг хүртээмжтэй болгох зорилгоор 8 сургуульд сэтгэл зүйчийн булгэм байгуулж, давхардсан тоогоор 3,443 сурагчид мэргэжлийн зөвлөгөө үзүүллээ. Урьдчилсан сэргийлэх ажлын хүрээнд 2939 сурагчийг хамруулан электрон тамхины хэрэглээний тандалт судалгааг зохион байгуулж, үр | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | дунд суурилсан нөлөөллийн бичлэгүүдийг цувралаар хүргэж байна. Үе тэнгийн дээрэлхэлтийн эсрэг “Stop bully-Start kind” QR системийг сургууль, дотуур байрны орчинд тогтмол ажиллуулж, гомдол мэдээллийг шуурхай хүлээн авч байна. Түүнчлэн “Найрсаг сургууль”, “Хүүхэд бүр хайр” аяны хүрээнд Өмгөөлөгчдийн холбоотой хамтран хууль эрх зүйн сургалтуудыг тусгай хөтөлбөрийн дагуу үе шаттай зохион байгуулж байна.<br>Хүрсэн түвшин: 100%<br>Хавсралт: 2 файл | |
| 3.1.13 | Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байранд “Хүүхэд хөгжлийн өрөө”, “Охидын ариун цэврийн булан” байгуулж, үйл | Зохион байгуулалтын арга хэмжээ | “Охидын ариун цэврийн булан” байгуулсан дотуур байрын тоо “Хүүхэд хөгжлийн өрөө” – тэй дотуур байрын тоо | “Охидын ариун цэврийн булан” байгуулсан дотуур байр-13 (81.2%) “Хүүхэд хөгжлийн өрөө” – тэй дотуур байр – 10 (62.5%) | Эхний хагас жилд: “Охидын ариун цэврийн булан” байгуулсан дотуур байр-13 (81.2%) “Хүүхэд хөгжлийн өрөө” – тэй дотуур байр – | Дотуур байрны суралцагчдын хөгжлийг дэмжих, эрүүл ахуйн тусламж үйлчилгээг хүртээмжтэй болгох чиглэлээр Боловсролын | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | ажиллагааг тогтмолжуулна. | | | | 10 (62.5%) Жилийн эцэст: “Охидын ариун цэврийн булан” байгуулсан дотуур байр-14 (87.5%) “Хүүхэд хөгжлийн өрөө” – тэй дотуур байр – 11 (68.7%) | ерөнхий газар, НҮБ-ын Хүн амын сан болон “Охидын найз” төсөлтэй хамтран ажилласны үр дүнд тодорхой ахиц гарлаа. Тухайлбал, суурь түвшинд “Охидын ариун цэврийн булан” 13 дотуур байранд, “Хүүхэд хөгжлийн өрөө” 10 дотуур байранд байсан бол тайлант хугацаанд аймгийн хэмжээний нийт 17 дотуур байранд “Охидын ариун цэврийн булан”-байгуулж, үйл ажиллагааг нь тогтмолжуулав. Мөн “Хүүхэд хөгжлийн өрөө”-г 15 дотуур байр буюу 88.2 хувьд нь байгуулан иж бүрэн тохижуулснаар суралцагчид чөлөөт цагаа үр бүтээлтэй өнгөрүүлэх, өөрийгөө хөгжүүлэх таатай орчин бүрдээд байна.<br>Хүрсэн түвшин: 100% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Хавсралт: 2 файл | |
| 3.2. | Багшийн мэргэжлийн ур чадварыг тасралтгүй дээшлүүлэн, хөдөлмөрийн бүтээмжид суурилсан үнэлэмж, нийгмийн баталгааг хангана. | 482.0 сая | Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн хувиар | 100 | 100 | Зорилтын хүрээнд 9 арга хэмжээг, үүнээс эхний хагас жилд 8 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөн хэрэгжилтийг 100 хувьд хангаж ажиллалаа. | 100% |
| 3.2.1 | “Багшийн 3 тулгуурт бодлого” цогц арга хэмжээний хүрээнд “Эрдэм” хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ. | 30.0 сая | Хэрэгжилтийн хувиар | 100 | Эхний хагас жилд: 100<br>Жилийн эцэст: 100 | Дорнод аймгийн Засаг даргын 2026 оны 45 дугаар захирамжийн “Эрдэм” төсөл 4 зорилт, 9 арга хэмжээний хүрээнд 30.0 сая төгрөгийн санхүүжилттэйгээр хэрэгжиж байна. Зорилт 1-ийн хүрээнд багш нарын 89.2 хувь буюу 778 багш AI технологи, цахим хэрэглэгдэхүүн ашиглаж хэвшлээ. Сургалтын хөтөлбөрийг сайжруулахаар 598 судалгаат хичээл зааж, 762 хэлэлцүүлэг өрнүүлэн, Gemini, | 100% |

***Эх сурвалж:*** *А.Мөнхжаргал /Статистикийн мэдээлэл, хяналт, шинжилгээ үнэлгээ хариуцсан ахлах арга зүйч/*
*Дорнод аймгийн Боловсролын газар, Бодлогын хэрэгжилтийн хэлтэс, 304 тоот, Емэйл: munkhjargal6lgv@moes.edu.mn Утас: 89336089*

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Canva, MozaWeb зэрэг программаар агуулга бэлтгэх цагийг 50 хувь хэмнэв. Мөн VARK арга зүйгээр сурагчдын хэв шинжийг илрүүлж, "Зэрэгтэй багшийн манлайлал" бичлэг, номыг үндэсний болон орон нутгийн түвшинд түгээн дэлгэрүүллээ Зорилт 2-ын хүрээнд 32 цэцэрлэгийн 270 багшийг МУИС-ийн Зүүн бүсийн сургуульд сургаж, суралцахуйн үр дүнг тооцох арга зүйд сургав. ЕБС-ийн багш нарын сургалтыг судлагдахуун бүрээр 14 цахим анги үүсгэн зохион байгуулснаар дижитал технологи, ухаалаг хэрэгсэл ашиглах хандлагад ахиц гарлаа. Зорилт 3-ын хүрээнд СӨБ-д 51 мэргэжлийн бүлгийн ажилд 901 удирдах ажилтан, | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | багшийг хамруулж, арга зүйн 12 нэр төрлийн ном, гарын авлага гаргав. ЕБС-д 148 мэргэжлийн бүлэг байгуулж, 313 сургалт, 339 судалгаат хичээл, 288 хэлэлцүүлэг хийлээ. Мөн 26 сургууль хамтран 278 судалгаат хичээл зааж, 213 сайн хичээлийн сан бүрдүүлсэн бөгөөд байгууллага дээр 243 сургалт, 213 хэлэлцүүлэг, 40 зөвлөмж өгч, 82 гарын авлага боловсруулав. Зорилт 4-ийн хүрээнд хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, менежментийг сайжруулах, авлига, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хүүхэд хамгааллыг дэмжих чиглэлээр удирдах ажилтны Лхагва гарагийн 13 уулзалтаар 65 танилцуулга, | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | зөвлөмж өгөв. Үр дүнд нь цаг үеийн мэдээлэл шуурхай хүрч, хуулийн биелэлт 80-100 хувийн хэрэгжилттэй байна.<br>Хүрсэн түвшин: 100%<br>Хавсралт: 2 файл | |
| 3.2.2 | Үнэлгээний үр дүн хангалтгүй байгаа цэцэрлэг, сургуулийн менежементийг сайжруулах, үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, багш нарыг сургах, мэргэжлийн бүлгээр ажиллах нөхцөлийг бүрдүүлэх | Зохион байгуулалтын арга хэмжээ | Арга зүйн дэмжлэг үзүүлсэн байгууллагын тоо | Арга зүйн дэмжлэг үзүүлсэн байгууллагын тоо - СӨБ - 6, ЕБС - 6 | Эхний хагас жилд: Арга зүйн дэмжлэг үзүүлсэн байгууллагын тоо - СӨБ - 3, ЕБС - 3 Жилийн эцэст: Арга зүйн дэмжлэг үзүүлсэн байгууллагын тоо - СӨБ - 3, ЕБС - 3 | Байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнг харгалзан, үйл ажиллагаа нь хангалтгүй үнэлэгдсэн цэцэрлэг, сургуулиудын менежментийг сайжруулах, багш нарыг чадавхижуулах зөвлөн туслах ажлыг үе шаттай зохион байгууллаа. Сургуулийн өмнөх боловсролын хүрээнд 2025 оны үнэлгээгээр түвшин буурсан Хэрлэн сумын 5 дугаар цэцэрлэг, хоёр жил дараалан V түвшинд үнэлэгдсэн | 100% |

***Эх сурвалж:*** *А.Мөнхжаргал /Статистикийн мэдээлэл, хяналт, шинжилгээ үнэлгээ хариуцсан ахлах арга зүйч/*
*Дорнод аймгийн Боловсролын газар, Бодлогын хэрэгжилтийн хэлтэс, 304 тоот, Емэйл: munkhjargal6lgv@moes.edu.mn Утас: 89336089*

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Чойбалсан сумын цэцэрлэг, мөн түвшин ахисан ч удирдлагын манлайлал хангалтгүй байгаа Гурванзагал сумын цэцэрлэгүүдэд зөвлөн туслах ажил үйлчилгээ үзүүлэв. Үйл ажиллагааны хүрээнд нийт 55 хүнд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж, 13 багшийн чиглүүлэгтэй тоглоомын үйл ажиллагаанд ажиглалт хийн, 8 төлөвлөлтийг засан сайжрууллаа. Уг ажлаар байгууллагуудын өөрийн үнэлгээний явцтай танилцаж, үнэлгээний багийг журмын дагуу байгуулах, нотлох баримт бүрдүүлэх, эцэг эхийн санал асуулгын хуудсыг оновчтой боловсруулах, хүүхдийн хөгжлийн үнэлгээг баримтжуулах зэрэг 9 чиглэлээр | |

**_Эх сурвалж:_** *А.Мөнхжаргал /Статистикийн мэдээлэл, хяналт, шинжилгээ үнэлгээ хариуцсан ахлах арга зүйч/*
*Дорнод аймгийн Боловсролын газар, Бодлогын хэрэгжилтийн хэлтэс, 304 тоот, Емэйл: munkhjargal6lgv@moes.edu.mn Утас: 89336089*

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | зөвлөмж хүргүүлэв. Түүнчлэн менежментийг сайжруулах зорилгоор “Цэцэрлэгийн эрхлэгчийн мэргэжлийн чадавхыг дэмжих нь” сургалтыг зохион байгуулж, 31 цэцэрлэгийн эрхлэгчийг шалгуурын дагуу өөрийн үнэлгээ хийх арга зүйд сургаж, туршлага хуваалцуулсан. Ерөнхий боловсролын сургуулийн хүрээнд Байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээгээр 5 дугаар түвшинд үнэлэгдсэн Хэрлэн сумын 11 дүгээр сургууль, Хан-Уул сургууль, Халхгол сумын сургуулиудыг эхний хагас жилд сонгон ажиллав. Эдгээр сургуулиудад ажиллах хугацаандаа 99 багшийн хичээлд | |

**Эх сурвалж:** А.Мөнхжаргал /Статистикийн мэдээлэл, хяналт, шинжилгээ үнэлгээ хариуцсан ахлах арга зүйч/
Дорнод аймгийн Боловсролын газар, Бодлогын хэрэгжилтийн хэлтэс, 304 тоот, Емэйл: munkhjargal6lgv@moes.edu.mn Утас: 89336089

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ажиглалт хийж, давхардсан тоогоор 225 багш, удирдах ажилтанд ганцаарчилсан зөвлөгөө өгөн, 199 ажилтны бичиг баримтын бүрдэл, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөтэй танилцаж арга зүйн удирдлагаар хангалаа. Зөвлөн туслах ажлын үр дүнд нийт 20 багш хичээлийн бэлтгэл, хөтөлбөр боловсруулалтдаа орчин үеийн заах арга зүйн элементүүдийг тусгаж, сургалтын технологио шинэчлэх арга барилд суралцсан байна.<br>Хүрсэн түвшин: 100%<br>Хавсралт: 1 файл | |
| 3.2.3 | Мэргэжлийн багш нарын бүлгээр багшлахуйг дэмжин ажиллана. | Зохион байгуулалтын арга хэмжээ | Хэрэгжилтийн хувь | 100 | Эхний хагас жилд: 100<br>Жилийн эцэст: 100 | Сургуулийн өмнөх боловсролын хүрээнд судлагдахуунд суурилсан 7, удирдах ажилтан | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | болон багшийн туслахын 2, нийт 9 мэргэжлийн хөгжлийн бүлгийг ажиллуулж, үйл ажиллагаанд орон нутгийн бүлгээр 626, цэцэрлэгийн бүлгээр 275 буюу нийт 901 удирдах ажилтан, багшийг хамрууллаа. Салбарын хэмжээнд 4 чиглэлийн 99 удаагийн сургалт зохион байгуулж, давхардсан тоогоор 3780 удирдах ажилтан, багш, туслах багшид арга зүйн бодит дэмжлэг үзүүлэв. Боловсролын газрын даргын 2025 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн удирдамжийн хэрэгжилтийг дүгнэхэд 901 албан хаагч хамрагдсан нь дунджаар 1 хүн 2 мэргэжлийн бүлэгт тогтмол суралцаж чадавхжсаныг харуулж байна. Мөн нийт багш нарын 92 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хувь нь сургалтын хөтөлбөрийн 4 үндсэн арга зүйг бүрэн эзэмшиж, практикт хэрэгжүүлсэн бөгөөд 6 шинэ арга зүйг туршин нэвтрүүллээ. Түүнчлэн нийт 32 цэцэрлэг сургалтын хөтөлбөртөө 1-3 удаагийн засан сайжруулалт хийж, багш нарын арга зүйг баяжуулах чиглэлээр “Багшийн туслахын гарын авлага”, “СӨБ-ын хүрээнд шинээр гарсан дүрэм журмын эмхтгэл” зэрэг мэргэжлийн 12 нэр төрлийн ном, гарын авлагыг боловсруулан практикт нийлүүлэв. Ерөнхий боловсролын сургуулийн түвшинд судлагдахууны 22, суралцахуйд суурилсан 126, нийт 148 мэргэжлийн багш нарын хөгжлийн бүлгийг сургууль бүр дээр | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | идэвхжүүлэн ажиллууллаа. Тус бүлгүүдээс багшлахуй болон суралцахуйг дэмжих чиглэлээр 313 удаагийн сургалт, 339 судалгаат хичээл, 288 хэлэлцүүлэг, 243 удаагийн тусгайлсан онолын сургалтыг шат дараатай зохион байгуулж, 1200 гаруй багш, удирдах ажилтны заах арга зүйн ур чадварыг ажлын байран дээр нь дээшлүүлсэн байна. Үйл ажиллагааны үр дүнд аймаг, сургуулийн хэмжээнд 394 удаа шилдэг арга барилыг түгээн дэлгэрүүлж, туршлага солилцох уулзалт, хэлэлцүүлгийг 288 удаа зохион байгуулж, 1990 багш, удирдлагыг хамруулсан бөгөөд Боловсролын газрын цахим | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хуудсаар дамжуулан сайн туршлагуудыг нийтэд сурталчлах ажлыг зохион байгууллаа.<br>Хүрсэн түвшин: 100%<br>Хавсралт: 5 файл | |
| 3.2.4 | “Зөвлөх багшийн манлайлал” арга хэмжээг хэрэгжүүлж, сайн туршлагыг түгээн дэлгэрүүлнэ. | Зохион байгуулалтын арга хэмжээ | Зөвлөх үйлчилгээний тоо Туршлагаа түгээсэн багшийн тоо | Зөвлөх үйлчилгээний тоо -5 Туршлагаа түгээсэн багшийн тоо -61 | Эхний хагас жилд: 2 / 30 Жилийн эцэст: 3 / 30 | Зөвлөх багш нарын мэдлэг, туршлагад тулгуурлан багш нарын мэргэжлийн болон технологийн ур чадварыг жигд хангах, хамтын ажиллагааг сэтгэл зүйн эерэг орчинд өрнүүлэх зорилготой "Зөвлөх багшийн бүсчилсэн манлайлал" арга хэмжээг "Боловсролыг дэмжих жил"-ийн үндсэн зорилтуудтай уялдуулан үе шаттай зохион байгуулж байна. Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын 6 зөвлөх багшаар удирдуулан "Сэтгэл зүйн дархлаа ба | 100% |

***Эх сурвалж:*** *А.Мөнхжаргал /Статистикийн мэдээлэл, хяналт, шинжилгээ үнэлгээ хариуцсан ахлах арга зүйч/*
*Дорнод аймгийн Боловсролын газар, Бодлогын хэрэгжилтийн хэлтэс, 304 тоот, Емэйл: munkhjargal6lgv@moes.edu.mn Утас: 89336089*

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | илтгэх ур чадвар", "Технологийн шийдэл", "Ялгаатай арга зүй ба хичээлийн судалгаа" сэдэвт гурван үндсэн модуль сургалтыг зохион байгуулж, зөвлөх зэрэгтэй 50 багшийг чадавхжууллаа. Мөн тэднийг 5 бүсэд хуваарилан ажиллуулснаар хамтын ажиллагааг идэвхжүүлэх, бүсчилсэн манлайллыг дэмжих суурь нөхцөлийг бүрдүүлсэн. "Ялгаатай арга зүй ба хичээлийн судалгаа" модулийн хүрээнд “Зөвлөх багшийн мастер класс-2026” арга хэмжээг зохион байгуулж, 36 зөвлөх багш нийт 450 багшид ялгаатай арга зүй (VARK загвар), судалгаат хичээлийн үеийн VARK ажиглалт, хичээлийн дараах хэлэлцүүлэг (VARK | |

**Эх сурвалж:** А.Мөнхжаргал /Статистикийн мэдээлэл, хяналт, шинжилгээ үнэлгээ хариуцсан ахлах арга зүйч/
Дорнод аймгийн Боловсролын газар, Бодлогын хэрэгжилтийн хэлтэс, 304 тоот, Емэйл: munkhjargal6lgv@moes.edu.mn Утас: 89336089

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | интеграц) болон судалгаат хичээлийг оношлох арга зүйг амжилттай түгээлээ. Түүнчлэн ялгаатай арга зүйн практик хэрэгжилтийг турших зорилгоор Баянтүмэн, Дашбалбар, Хан-Уул, Чойбалсан (Цагаан-Овоо) болон 8, 12 дугаар сургуулиудын 7 дугаар ангийн сурагчдаас суралцах хэв маягийг тодорхойлох сорил авч, сурагч бүрийн суралцах хэв шинжид тулгуурласан нээлттэй хичээлүүдийг үр дүнтэй зохион байгуулсан байна.<br>Хүрсэн түвшин: 4 / 42<br>Хавсралт: 3 файл | |
| 3.2.5 | Бүх шатны сургалтын байгууллагад хөгжлийн бэрхшээлтэй | Зохион байгуулалтын арга хэмжээ | Хэрэгжилтийн хувиар | 100 | Эхний хагас жилд: 100<br>Жилийн эцэст: 100 | "Тусгай хэрэгцээт боловсролын чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх хүрээнд хөгжлийн | 100% |

**Эх сурвалж:** А.Мөнхжаргал /Статистикийн мэдээлэл, хяналт, шинжилгээ үнэлгээ хариуцсан ахлах арга зүйч/
Дорнод аймгийн Боловсролын газар, Бодлогын хэрэгжилтийн хэлтэс, 304 тоот, Емэйл: munkhjargal6lgv@moes.edu.mn Утас: 89336089

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хүүхэдтэй ажиллаж буй багшийг чадавхжуулахад дэмжлэг үзүүлэх, тэдэнд холбогдох хууль тогтоомжид заасан нэмэгдэл, урамшуулал олгоно. | | | | | ялгаатай хүүхэдтэй ажиллаж буй багш нарыг чадавхжуулах цуврал сургалтуудыг зохион байгууллаа. Монголын тусгай Олимпын хороотой хамтран оюуны бэрхшээлтэй хүүхдүүдийг урлаг, спортоор дамжуулан нийгэмшүүлэх, бие бялдрыг нь чийрэгжүүлэх зорилгоор “Бүжгийн багш, дасгалжуулагч бэлтгэх” сургалтад 21 цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн 26 багшийг хамруулав. Мөн Дэлхийн Зөн Монгол ОУБ болон “Энэрлийн түүчээ” ТББ-тай хамтран зохион байгуулсан “Модуль-4” сургалтад 119 багш хамрагдсанаас 25 нь “Сургагч багш”-аар бэлтгэгдэж, арга зүйн зөвлөгөө | |

***Эх сурвалж:*** *А.Мөнхжаргал /Статистикийн мэдээлэл, хяналт, шинжилгээ үнэлгээ хариуцсан ахлах арга зүйч/*
*Дорнод аймгийн Боловсролын газар, Бодлогын хэрэгжилтийн хэлтэс, 304 тоот, Емэйл: munkhjargal6lgv@moes.edu.mn Утас: 89336089*

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | өгөх дотоод нөөцийг нэмэгдүүллээ. Түүнчлэн аутизмын хүрээний эмгэгтэй хүүхэд, тэдний гэр бүлийг дэмжих зорилгоор БЕГ-аас зохион байгуулсан цахим сургалтад 191 багш, 94 эцэг эхийг хамруулж, 24 хүнд ганцаарчилсан мэргэжлийн зөвлөгөө мэдээлэл хүргэв. 2026 оны эхний хагас жилийн байдлаар аймгийн хэмжээнд 14 сургуулийн 125 багш, 16 цэцэрлэгийн 150 багш буюу нийт 275 багшид нэмэгдэл хөлс олгоод байна. Үүнд нийт 102.0 сая төгрөг зарцуулсан нь өмнөх оны мөн үеэс 51.5 сая төгрөгөөр буюу 2 дахин нэмэгджээ. Эдгээр цогц арга хэмжээ нь тусгай хэрэгцээт боловсролын хүртээмж, хүний нөөцийн тогтвортой байдлыг баталгаж, | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах багш нарын мэргэжлийн чадавх, хариуцлага, урам зоригийг дээшлүүлсэн бодит дэмжлэг боллоо.<br>Хүрсэн түвшин: 100%<br>Хавсралт: 2 файл | |
| 3.2.6 | “Цэцэрлэгийн багш” төслийг хэрэгжүүлж, нийгмийн баталгааг хангахад дэмжлэг үзүүлнэ. | 42.0 сая | Дэмжлэг урамшуулал авсан багшийн тоогоор | 4 | Эхний хагас жилд: -<br>Жилийн эцэст: 2 | Дорнод аймгийн Засаг даргын 2026 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн А/47 тоот захирамжаар батлагдсан “Цэцэрлэгийн багш” болзолт уралдааныг 02 дугаар сарын 12-ны өдрөөс 05 дугаар сарын 19-ний өдрүүдэд амжилттай зохион байгуулж дууслаа. Тус уралдаан нь сургуулийн өмнөх боловсролын салбарын багш, ажилчдын хөдөлмөрийн үнэлэмж, мэргэжлийн нэр хүндийг | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | дээшлүүлэх, нийгмийн хамгааллыг дэмжих, багшлахуйн ур чадвар, санал санаачилгыг урамшуулахын зэрэгцээ хүүхэд нэг бүрийн хөгжлийг дэмжих шилдэг арга зүй, тэргүүн туршлагыг түгээн дэлгэрүүлэх зорилгын хүрээнд зохион байгуулагдав. Болзолт уралдааныг “Багш” болон “Багшийн туслах” гэсэн 2 төрлөөр, 2 үе шат бүхий 6 даалгаврын хүрээнд явуулсан бөгөөд “Багш” төрөлд 19 цэцэрлэгийн 34 багш, “Багшийн туслах” төрөлд 15 цэцэрлэгийн 19 багшийн туслах оролцлоо. Уралдаанд тэргүүлсэн шилдэг 2 багш, багшийн туслахад орон сууцны урьдчилгаа буюу тус бүр 20.0 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | сая төгрөгийн дэмжлэг үзүүлэхээр шийдвэрлэсэн.<br>Хүрсэн түвшин: 2<br>Хавсралт: 2 файл | |
| 3.2.7 | "Бага ангийн багш" төслийг хэрэгжүүлж, нийгмийн баталгааг хангахад дэмжлэг үзүүлнэ. | 420.0 сая | Дэмжлэг урамшуулал авсан багшийн тоогоор | 28 | Эхний хагас жилд: -<br>Жилийн эцэст: 21 | Дорнод аймгийн Засаг даргын 2026 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн А/44 дүгээр захирамжаар батлагдсан “Бага ангийн багшийг дэмжих” төслийг удирдамжийн дагуу амжилттай хэрэгжүүллээ. Уралдаанд аймгийн хэмжээний ерөнхий боловсролын 21 сургуулиас шалгарсан 42 багш бүртгүүлэн оролцож, 1-3 шатны шалгаруулалтад оролцлоо. Төслийн эцсийн шалгаруулалтын нэгдсэн дүнгээр удирдамжид заасан шалгуур үзүүлэлтүүдийг бүрэн хангаж, сургууль болон сургалтын орчиндоо | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | бодит хувь нэмэр оруулсан 21 шилдэг бага ангийн багш тус бүрд орон сууцны урьдчилгаа төлбөр болох 20.0 сая төгрөгийн урамшуулал олгохоор шийдвэрлэсэн. Уралдаанд шалгарсан 21 багш сургуулийнхаа орчинд нийт 69,934,578 төгрөгний өртөг бүхий бүтээлч ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна. Үүнд “Хүн ба байгаль” хичээлийн туршилт болон суралцагчдад зориулсан танин мэдэхүйн олон талт үйл ажиллагааны чиглэлээр 33,003,890 төгрөгний бүтээлч ажил хийгдсэн бол “Mozaik education” хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн болон “Хүн ба байгаль” хичээлийн хүндэвтэр агуулгын хүрээнд сургалтын | |

***Эх сурвалж:*** *А.Мөнхжаргал /Статистикийн мэдээлэл, хяналт, шинжилгээ үнэлгээ хариуцсан ахлах арга зүйч/*
*Дорнод аймгийн Боловсролын газар, Бодлогын хэрэгжилтийн хэлтэс, 304 тоот, Емэйл: munkhjargal6lgv@moes.edu.mn Утас: 89336089*

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | орчин, хэрэглэгдэхүүнийг сайжруулах чиглэлээр 36,930,688 төгрөгний хөрөнгө оруулалт, тохижилтын ажлыг тус тус орон нутагтаа өрнүүлсэн байна. Уралдаанд оролцсон 42 багшийн туршлагыг youtube-д байршуулж, "Дорнод аймгийн Боловсролын газар", "Дорнод бага боловсрол" пэйж хуудсаар түгээн дэлгэрүүлэлт хийсэн.<br>Хүрсэн түвшин: 21<br>Хавсралт: 3 файл | |
| 3.2.9 | Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш, ажилтныг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоонд хамруулах; | Зохион байгуулатын арга хэмжээ | Хэрэгжилтийн хувь | 100 | Эхний хагас жилд: 100<br>Жилийн эцэст: 100 | Эрүүл мэндийн сайдын 2017 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн А/145 дугаар тушаалын дагуу 6 сар тутамд 1 удаа сургуулийн өмнөх боловсролын байгууллага, ерөнхий | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | боловсролын сургуульд ажиллаж буй хүнсний бүтээгдэхүүнтэй шууд харьцдаг 261 хүнсний нярав, тогооч нарыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд 100 хувь хамрагдлаа.<br>Хүрсэн түвшин: 100<br>Хавсралт: 1 файл | |
| 3.3. | Мэргэжлийн боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, боловсролын чанарыг дээшлүүлэн, үндэсний хэмжээнд өрсөлдөх чадвартай хүний нөөцийг бэлтгэнэ. | Зохион байгуулалтын арга хэмжээ | Төлөвлөсөн арга хэмжээнүүдийн хэрэгжилтийн хувиар | 100 | 100 | Зорилтын хүрээнд 4 арга хэмжээг төлөвлөн хэрэгжилтийг 100 хувь хангаж ажиллалаа. | 100% |
| 3.3.1 | Мэргэжлийн боловсрол, сургалтад хамрагдалтыг нэмэгдүүлнэ. | Зохион байгуулалтын арга хэмжээ | Мэргэжлийн боловсрол, сургалтад хамрагдсан суралцагчийн 14-65 насны хүн амд эзлэх хувь | 2.02 | Эхний хагас жилд: 2.06<br>Жилийн эцэст: 2.1 | Дорнод аймаг дахь Политехник коллеж нь 2025-2026 оны хичээлийн жилд 19 мэргэжлээр 575 суралцагч элсүүлэхээр төлөвлөснөөс намрын элсэлтээр 419, 2026 оны | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | өвлийн элсэлтээр 80 суралцагч, нийт 499 суралцагч элсүүлсэн. Нийт 19 мэргэжлээр 1217 суралцагч суралцаж байгаа бөгөөд 14-65 насны хүн амд эзлэх хувь 2025 оноос 0.15 хувиар нэмэгдэж, 2.17 хувьд хүрсэн байна. Батлан хамгаалахын сайд, Боловсролын сайд, Гэр бүл, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын хамтарсан 2026 оны А/30-А/12/А/04 дугаар тушаалаар баталсан "Цэргийн алба хаагчдийг мэргэжлийн сургалтанд хамруулах, сургалт зохион байгуулах журам"-ыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд "Мэргэжилтэй цэрэг" хөтөлбөрийг хэрэгжүүлж, Зэвсэгт хүчний 327-р ангийн 92 хугацаат цэргийн албан хаагчдыг Гагнуурчин, | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | механикжсан тээврийн хэрэгсэл, механизмын засвар үйлчилгээ, цахилгаан хангамж тоног төхөөрөмж гэсэн 3 мэргэжлээр 21 хоногийн хугацаанд мэргэжлийн сургалтад хамруулж, чадамжийн гэрчилгээ олгосон. Мэргэжлийн боловсролын нэр хүнд, сургалтын чанарыг сайжруулж, суралцагчдын урсгалыг татах зорилгоор Дорнод Политехник коллежийн "Оёмол бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн мэргэжил" (1 болон 3 жилийн), "Уул уурхайн машин механизмын засвар үйлчилгээ" (3 жилийн) болон "Мал, амьтны эмнэлэг зүй" (3 жилийн) зэрэг техникийн болон мэргэжлийн боловсролын 4 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хөтөлбөрийг 5 жилийн хугацаатай амжилттай магадлан итгэмжлүүлж, гэрчилгээг гардан авлаа.<br>Хүрсэн түвшин: 100%<br>Хавсралт: 7 файл | |
| 3.3.2 | Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын байгууллагын суралцагч болон төгсөгчийг ажлын байртай холбох ажлыг орон нутгийн байгууллага, аж ахуйн нэгж байгууллагуудтай хамтран зохион байгуулна. | Зохион байгуулалтын арга хэмжээ | Зохион байгуулсан ажлын гүйцэтгэлийн хувь Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн хувь | Зохион байгуулсан ажлын гүйцэтгэлийн хувь 100 Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн хувь 67.1 | Эхний хагас жилд: Зохион байгуулсан ажлын гүйцэтгэлийн хувь 100 Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн хувь 67.2<br>Жилийн эцэст: Зохион байгуулсан ажлын гүйцэтгэлийн хувь 100 Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн хувь 67.3 | Орон нутаг дахь мэргэжлийн болон техникийн боловсрол, дээд боловсролын төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажил олгогчдыг татан оролцуулах чиглэлээр Политехник коллеж болон бусад байгууллагуудтай хамтран үр дүнтэй ажлуудыг зохион байгууллаа. Дорнод аймаг дахь Политехник коллеж нь 2026 онд гадаад хамтын ажиллагаагаа өргөжүүлж, БНСУ-ын Нисэхийн технологийн сургууль болон | 100% |

***Эх сурвалж:*** *А.Мөнхжаргал /Статистикийн мэдээлэл, хяналт, шинжилгээ үнэлгээ хариуцсан ахлах арга зүйч/*
*Дорнод аймгийн Боловсролын газар, Бодлогын хэрэгжилтийн хэлтэс, 304 тоот, Емэйл: munkhjargal6lgv@moes.edu.mn Утас: 89336089*

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | дотоодын Мандах их сургууль, Сити их сургуулиудтай хамтран ажиллах санамж бичгийг байгуулан ажиллав. Энэхүү түншлэлийн хүрээнд Цахилгаан хангамжийн тоног төхөөрөмжийн ашиглалт, Механик, Оёмол бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн чиглэлээр суралцаж буй залууст бакалаврын түвшинд шатлан суралцах, техникчээр мэргэжил дээшлүүлэх бодит боломж бүрдээд байна. Тухайлбал, Мандах их сургууль төгсөгчдийг дэмжиж сургалтын төлбөрийг 20 хувь хөнгөлөхөөр гэрээнд тусгасан. Төгсөгчдийг ажлын байраар хангах зорилгоор Хөдөлмөр, халамж үйлчилгээний газартай хамтран "Хөдөлмөр эрхлэлт-2026" яармагийг | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | зохион байгуулж, 100 гаруй аж ахуйн нэгжийг татан оролцууллаа. Уг арга хэмжээний үеэр төгсөх ангийн 400 гаруй суралцагч нээлттэй ажлын байрны зартай танилцаж, хөдөлмөр зуучлалын байгууллагад ажил хайгчаар болон цагийн ажил хийхээр бүртгүүлж, ажил олгогчидтой шууд холбогдсон байна. Политехник коллежийг 2025 онд төгссөн 425 суралцагчийн хөдөлмөр эрхлэлт 67.1% байна.<br>Хүрсэн түвшин: 100%<br>Хавсралт: 4 файл | |
| 3.3.3 | Ерөнхий боловсролын сургуулийн дунд, ахлах ангийн суралцагчдад ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалт, үйл ажиллагааг зохион | Зохион байгуулалтын арга хэмжээ | Хэрэгжилтийн хувь | 100 | Эхний хагас жилд: 100<br>Жилийн эцэст: 100 | Аймгийн Засаг даргын 2026 оны А/115 дугаар захирамжийн дагуу гадаадын 6, дотоодын 17 их, дээд сургууль, 15 байгууллагын төлөөллийг | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | байгуулна. | | | | | оролцуулсан “Мөрөөдлөө мэргэжил болгоё” өдөрлөгийг зохион байгуулж, гадаадын 6, дотоодын 17 их дээд сургууль, 15 төрийн төрийн бус байгууллага, нийт 39 байгууллагын 92 багш, оюутан, албан хаагчиид Ерөнхий боловсролын сургуулийн 9-12-р анги, ПТК-ийн 5325 суралцагчид ажил мэргэжлийн онцлог, тэтгэлэгт хөтөлбөрүүдийн танилцуулгыг түгээн, илтгэл тавьж, ирээдүйн мэргэжлээ сонгоход чиглэл, мэдээллээ хүргэсэн байна.Мөн 9, 12 дугаар ангийн 3,000 гаруй сурагчийг коллежийн дадлагын газартай танилцуулж, Онцгой байдал, Батлан хамгаалах, Хууль зүй, Дотоод хэргийн салбарын мэргэжил сурталчлах арга | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хэмжээнд 400 гаруй сурагчийг хамруулсан байна. Түүнчлэн сурагчдын мэргэжил сонголт, тандалт судалгаа, чадвар тогтоох тест, "Ажлын байртай танилцъя" аян болон "Мэргэжлээрээ бахархъя" эцэг эхийн уулзалтад 1,300 гаруй суралцагч оролцсон бөгөөд шалгалтын стресс бууруулах, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх хөтөлбөрт 420 гаруй сурагч хамрагдлаа. Тайлант хугацаанд аймгийн хэмжээнд давхардсан тоогоор 8,325 гаруй суралцагчид ажил мэргэжлийн чиг баримжаа олгох цогц мэдээлэл, зөвлөгөөг хүргэсэн.<br>Хүрсэн түвшин: 100%<br>Хавсралт: 4 файл | |
| 3.3.4 | Мэргэжлийн болон техникийн боловсрол, дээд | Зохион байгуулалтын арга хэмжээ | Хэрэгжилтийн хувь | 40 | Эхний хагас жилд: 40<br>Жилийн эцэст: | Мэргэжлийн болон техникийн боловсролын | 100% |

**Эх сурвалж:** А.Мөнхжаргал /Статистикийн мэдээлэл, хяналт, шинжилгээ үнэлгээ хариуцсан ахлах арга зүйч/
Дорнод аймгийн Боловсролын газар, Бодлогын хэрэгжилтийн хэлтэс, 304 тоот, Емэйл: munkhjargal6lgv@moes.edu.mn Утас: 89336089

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | боловсролын сургалтын байгууллагын суралцагчийг халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, үзлэг, шинжилгээ, оношилгоонд хамруулах арга хэмжээг авах; | | | | 100 | байгууллагын суралцагчдыг халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоонд үе шаттай хамруулан ажиллалаа. Политехник коллежийн дотуур байранд 2026 оны 01 дүгээр сарын 26-нд улаанбурхан өвчний тохиолдол бүртгэгдсэнтэй холбогдуулан нийт 98 суралцагчийг урьдчилан сэргийлэх вакцинд хамруулсан. “Мянган жаргалан” өрхийн эрүүл мэндийн төвтэй хамтран дотуур байрны 30 гаруй суралцагчийг ХДХВ/ДОХ, тэмбүү, элэгний В, С вирус илрүүлэх шинжилгээнд хамруулж, эрүүл мэндийн зөвлөгөө мэдээлэл өгч ажиллав. Мөн | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Хэрлэн сумын Засаг даргын 2/347 тоот хүсэлтийн хүрээнд “Асралт үйлс”, “Мянган жаргалан” өрхийн эрүүл мэндийн төвүүдтэй хамтран 400 гаруй суралцагчийг шээсний ерөнхий шинжилгээ, элэгний В, С вирус, ХДХВ/ДОХ, тэмбүү илрүүлэх шинжилгээнд эцэг эх, асран хамгаалагчийн зөвшөөрөлд үндэслэн хамруулж, зөвлөгөө өглөө. Түүнчлэн 200 гаруй суралцагчдад “БЗДХӨ-өөс урьдчилан сэргийлэх”, “Зөв хооллолт”, “Элэгний В, С вирусийн халдвар”, “Сүрьеэ өвчнөөс урьдчилан сэргийлье” сэдвээр сургалт, мэдээлэл зохион байгуулж, эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэв. “Бүх нийт боловсролын төлөө” төрийн бус | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байгууллага болон сургуулийн суралцагч хамгааллын багтай хамтран сургуулийн орчин, дотуур байр, эрсдэлт бүлгийн суралцагчид, эцэг эхийн төлөөллийг хамруулсан эрүүл мэндийн эрсдэлийн үнэлгээ хийж, урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан.<br>Хүрсэн түвшин: 100%<br>Хавсралт: 1 файл | |
| 3.4. | Насан туршийн боловсролын суралцахуйн бодлогыг хэрэгжүүлж, орон нутгийн иргэдийг сурч хөгжих тэгш боломж олгоно. | Зохион байгуулалтын арга хэмжээ | Төлөвлөсөн арга хэмжээнүүдийн хэрэгжилтийн хувиар | 100 | 100 | Зорилтын хүрээнд 4 арга хэмжээг төлөвлөн хэрэгжилтийг 100 хувь ханган ажиллалаа. | 100% |
| 3.4.1 | Хүүхэд, залуучуудад боловсрол нөхөн олгох, суралцуулах ажлыг нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар | Зохион байгуулалтын арга хэмжээ | Хамрагдсан суралцагчийн тоогоор | 33 | Эхний хагас жилд: 33<br>Жилийн эцэст: 11 | 2025-2026 оны хичээлийн жилд боловсрол нөхөн олгох сургалтаар нийт 33, үүнээс боловсролын түвшингээр авч үзвэл бага | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хангаж ажиллана. | | | | | боловсролд 1, суурь боловсролд 18, бүрэн дунд боловсролд 14 суралцагч суралцаж байна. Суурь боловсролыг 5, бүрэн дунд боловсролыг 9 сурагч суралцаж төгсөнө.<br>Хүрсэн түвшин: 100%<br>Хавсралт: 2 файл | |
| 3.4.2 | Цахим ур чадвар олгох сургалт зохион байгуулна. | Зохион байгуулалтын арга хэмжээ | Сургалтад хамрагдсан иргэдийн тоо | 2854 | Эхний хагас жилд: 1400<br>Жилийн эцэст: 1800 | Иргэдийн цахим ур чадвар, аюулгүй байдлыг дээшлүүлэх чиглэлээр Хэрлэн сумын 11 баг болон Баяндун, Халхгол, Матад, Дашбалбар, Сэргэлэн, Баян-Уул, Цагаан-Овоо сумдын нийт 1200 гаруй иргэнд цахим ур чадвар олгох, мэдээлэл зөвлөгөө өгөх ажлыг зохион байгуулаад байна. Тухайлбал, Дорнод аймаг дахь Төрийн цахим үйлчилгээний хэлтэстэй хамтран “Ахмадын хурдан клуб” үйл | 100% |

***Эх сурвалж:*** *А.Мөнхжаргал /Статистикийн мэдээлэл, хяналт, шинжилгээ үнэлгээ хариуцсан ахлах арга зүйч/*
*Дорнод аймгийн Боловсролын газар, Бодлогын хэрэгжилтийн хэлтэс, 304 тоот, Емэйл: munkhjargal6lgv@moes.edu.mn Утас: 89336089*

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ажиллагааг зохион байгуулж, үүнд Хэрлэн сумын 11 багийн 652 ахмадыг хамруулан цахим ур чадварыг нь дээшлүүллээ. Түүнчлэн иргэдийн цахим аюулгүй байдлыг хангах, төрийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор мэдээллийн аюулгүй байдал, цахим залилангаас урьдчилан сэргийлэх, төрийн үйлчилгээг цахимаар авах аргачлал болон хувийн мэдээллээ хамгаалах чиглэлүүдээр цогц сургалтуудыг зохион байгуулав. Эдгээр үйл ажиллагаа нь орон нутгийн иргэдийн цахим хэрэглээний соёл, аюулгүй байдлын мэдлэгийг дээшлүүлэхэд бодит дэмжлэг болсон байна. | |

**Эх сурвалж:** А.Мөнхжаргал /Статистикийн мэдээлэл, хяналт, шинжилгээ үнэлгээ хариуцсан ахлах арга зүйч/
Дорнод аймгийн Боловсролын газар, Бодлогын хэрэгжилтийн хэлтэс, 304 тоот, Емэйл: munkhjargal6lgv@moes.edu.mn Утас: 89336089

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | "Мэдлээ" цахим сургууль болон Боловсролын газар хамтран "Дижитал багш" танхим болон цахим хосолсон сургалт зохион байгуулж, ерөнхий боловсролын сургуулийн 906 багшийг хамруулж, цахим ур чадвар, хиймэл оюун ухааныг сургалтад хэрэглэх чадамжид суралцаж, мэргэжил арга зүйгээ дээшлүүлсэн.<br>Хүрсэн түвшин: 100%<br>Хавсралт: 1 файл | |
| 3.4.2 | Боловсролын үйлчилгээний гадна байгаа зорилтот бүлгийн (хөгжлийн бэрхшээлтэй, малчин өрхийн, ламхай, эрх нь хязгаарлагдсан, сургууль завсардсан) хүүхдийг мөшгөн судлах, боловсролд хамруулах, | Зохион байгуулалтын арга хэмжээ | Хэрэгжилтийн хувь | 50 | Эхний хагас жилд: 100<br>Жилийн эцэст: 100 | Ялгаатай хэрэгцээтэй хүүхдүүдийг боловсролд тэгш хамруулах, тэдний хөгжлийг дэмжих орон нутгийн төлөвлөгөөний хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн бүртгэл, хамрагдалтыг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллалаа. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | цахимаар сурах боломжийг бүрдүүлэх | | | | | Аймгийн хэмжээнд сургуулийн насны (6-18 насны) хөгжлийн бэрхшээлтэй нийт 260 хүүхэд бүртгэлтэй байгаагаас 2026 оны эхний хагас жилийн байдлаар ерөнхий боловсролын 22 сургуульд 202 хүүхэд буюу нийт суралцагчдын 77.6 хувь нь суралцаж байна. Энэ нь хамрагдалтын түвшин өмнөх хичээлийн жилээс 6.5 хувиар өссөн үзүүлэлт бөгөөд суралцаж буй бүх сурагчид эрүүл мэндийн оношилгоонд 100 хувь бүрэн хамрагдсан байна. Эцэг эх, асран хамгаалагчдын хүсэлтэд үндэслэн 119 хүүхдэд ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж байна. | |

**Эх сурвалж:** *А.Мөнхжаргал /Статистикийн мэдээлэл, хяналт, шинжилгээ үнэлгээ хариуцсан ахлах арга зүйч/*
*Дорнод аймгийн Боловсролын газар, Бодлогын хэрэгжилтийн хэлтэс, 304 тоот, Емэйл: munkhjargal6lgv@moes.edu.mn Утас: 89336089*

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Мөшгөх судалгаагаар илэрсэн, хүнд нөхцөлд амьдарч буй болон хөгжлийн ялгаатай байдлын улмаас сургуульд хамрагдаж чадаагүй 25 хүүхдийн мэдээллийн санг шинээр үүсгэн, хяналтыг тогтоосон. Танхимын сургалтад хамрагдах боломжгүй, байнгын асаргаа шаардлагатай эдгээр хүүхдүүдийг гэр бүл, орон нутгийн онцлогт нь нийцүүлэн хувилбарт болон цахим сургалтад хамруулах зорилготой “Гэрт хүрэх багц” төслийг хэрэгжүүлж байна. Уг төслийн гүйцэтгэгчээр хөгжлийн бэрхшээлтэй хөдөлмөр эрхлэгчдийн үйлдвэрчний эвлэлийн хороо шалгарч, 20.0 сая | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | төгрөгийн гэрээ байгуулах шатны ажил хийгдэж байгаа нь боловсролын үйлчилгээг тэгш, хүртээмжтэй хүргэх боломжийг бүрдүүлж байна. Малчин өрхийн 1214 хүүхэд сургуулийн өмнөх боловсролын байгууллагад, 4412 хүүхэд ерөнхий боловсролын сургуульд хамрагдан суралцаж байна. Алслагдсан баг болон хилчдийн хүүхдийг боловсролд тэгш хамруулах, сурч хөгжих таатай орчинг бүрдүүлэх зорилгоор байгуулсан Хилийн цэргийн 0198, 0306 дугаар анги дахь цэцэрлэгийн 3 бүлэгт 68 хүүхэд, (үүнээс 6 нь малчин өрхийн хүүхэд), Мэнэн багийн бага сургуульд 1-5 дугаар ангийн 23 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | суралцагч хамрагдан суралцаж байна. Шашны сургуулийн хүүхэд байхгүй, Сүм хийдэд шавилан суудаг 1 хүүхэд боловсролын үйлчилгээнд хамрагдаж байна.<br>Хүрсэн түвшин: 100<br>Хавсралт: 3 файл | |
| 3.4.3 | Бүх насны иргэдэд чиглэсэн сургалт, нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулна. | Зохион байгуулалтын арга хэмжээ | Хэрэгжилтийн арга хэмжээ | 100 | Эхний хагас жилд: 100<br>Жилийн эцэст: 100 | Насан туршийн суралцахуйн төвөөс насанд хүрэгчдийн сурч боловсрох, хөгжих хэрэгцээг хангах, иргэдийн амьдрах чадвар, танин мэдэхүйг дээшлүүлэх зорилгоор 12 үндсэн чиглэлийн хүрээнд нийт 37 удаагийн танхимын, 2 удаагийн цахим сургалтыг амжилттай зохион байгууллаа.<br>Тайлант хугацаанд танхимын сургалтад 1493 иргэн, цахим сургалтад 40 гаруй иргэн, нийт 1530 гаруй иргэнд насан | 100% |

**Эх сурвалж:** А.Мөнхжаргал /Статистикийн мэдээлэл, хяналт, шинжилгээ үнэлгээ хариуцсан ахлах арга зүйч/
Дорнод аймгийн Боловсролын газар, Бодлогын хэрэгжилтийн хэлтэс, 304 тоот, Емэйл: munkhjargal6lgv@moes.edu.mn Утас: 89336089

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | туршийн боловсролын үйлчилгээг хүргэж ажилласан байна. Сургалтуудаас санхүүгийн болон эрүүл мэндийн боловсрол олгох чиглэлийн хөтөлбөрүүд хамгийн их эрэлттэй, иргэдийн оролцоо өндөртэй, үр дүнтэй байлаа.<br>Хүрсэн түвшин: 100%<br>Хавсралт: 1 файл | |
| 3.5. | Бүх шатны боловсролын сургалтын үйл ажиллагааг суралцагчийн хэрэгцээнд нийцсэн тэгш хүртээмжтэй байх нөхцөлийг хангуулна. | Зохион байгуулалтын арга хэмжээ | Төлөвлөсөн арга хэмжээнүүдийн хувиар | 100 | 100 | Зорилтын хүрээнд 4 арга хэмжээг төлөвлөснөөс 3 арга хэмжээг 100 хувь хэрэгжүүлсэн. Үлдсэн 1 арга хэмжээ нь Монгол Улсын Засгийн газрын 2026 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн "Салбарын хяналт шалгалтын талаар авах зарим арга хэмжээний тухай" 115 дугаар тогтоол гарсантай холбоотойгоор цуцлагдсан тул гүйцэтгэлийн | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | үнэлгээг тооцох боломжгүй болсон болно. | |
| 3.5.1 | Салбарын хяналтын чиглэлээр их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн объектод төлөвлөгөөт хяналт шалгалт хийнэ. | Зохион байгуулалтын арга хэмжээ | Хяналт шалгалт хийсэн обьектын тоо Эрсдэлийн түвшин буурсан хувиар | Хяналт шалгалт хийх обьектын тоо -9 Эрсдэлийн түвшин- 50.7 | Эхний хагас жилд: Обьектын тоо -6 Эрсдэл буурах хувь- 4.2 Жилийн эцэст: Обьектын тоо -9 Эрсдэл буурах хувь- 5.7 | МУ-ын Засгийн газрын 2026 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн "Салбарын хяналт шалгалтын талаар авах зарим арга хэмжээний тухай" 115 дугаар тогтоолоор 2026 оны төлөвлөгөөт болон УСХШ-ыг цуцлагдсан. Тус тушаал гарахаас өмнө Боловсролын яам, Эрүүл мэндийн яамны салбарын улсын ерөнхий байцаагчдын баталсан 2026 оны 03-00/07 дугаар удирдамжаар Хэрлэн сумын 5 дугаар сургуульд төлөвлөгөөт хяналт шалгалт хийн, БШУ-ны сайдын 2024 оны А/150 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаар батлагдсан 03/6.1-2 кодтой ерөнхий боловсролын сургалтын | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байгууллагын үйл ажиллагааг шалгах хяналтын хуудасны 66 асуулгаар үнэлэхэд хууль сахин мөрдөлт 77.7%, эрсдэл үүсэх магадлал 22,3% хувь буюу бага эрсдэлтэй шалгагдан, эрсдэлийн түвшин 26.7 хувиар буурсан байна. Хяналт шалгалтаар илэрсэн 7 зөрчил, дутагдлыг арилгах мэргэжил, арга зүйн дэмжлэгийг сургуулийн 6 албан хаагчид өгч, зөвлөн тусалж ажилласан.<br>Хүрсэн түвшин: Хяналтад хамрагдсан обьект 1, эрсдэл буурсан хувь 26.7%<br>Хавсралт: 14 файл | |
| 3.5.2 | Салбарын хяналтын чиглэлээр урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийнэ. | Зохион байгуулалтын арга хэмжээ | Гүйцэтгэл | 100 | Эхний хагас жилд: 100<br>Жилийн эцэст: 100 | МУ-ын Засгийн газрын 2026 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн "Салбарын хяналт шалгалтын талаар авах зарим арга хэмжээний тухай" 115 дугаар | 0% |

**Эх сурвалж:** *А.Мөнхжаргал /Статистикийн мэдээлэл, хяналт, шинжилгээ үнэлгээ хариуцсан ахлах арга зүйч/*
*Дорнод аймгийн Боловсролын газар, Бодлогын хэрэгжилтийн хэлтэс, 304 тоот, Емэйл: munkhjargal6lgv@moes.edu.mn Утас: 89336089*

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тогтоолоор 2026 оны төлөвлөгөөт болон УСХШ-ыг цуцлагдсан тул хяналт шалгалт хийгдээгүй.<br>Хүрсэн түвшин: 2026 онд хяналт шалгалт цуцлагдсан. Үнэлэх боломжгүй.<br>Хавсралт: 2 файл | |
| 3.5.3 | Өмчийн бүх хэлбэрийн боловсрол, сургалтын байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийн, зөвлөн тусалж, арга зүйн дэмжлэг үзүүлнэ. | Шатахууны зардал | Зохион байгуулалтын арга хэмжээ | Хамрагдсан байгууллагын тоо | Эхний хагас жилд: СӨБ - 8 ЕБС - 7 Жилийн эцэст: СӨБ - 8 ЕБС - 7 | Боловсролын газрын даргын баталсан удирдамжийн дагуу сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт, хууль тогтоомжийн биелэлтэд хяналт-шинжилгээ хийж, зөвлөн туслах ажлыг зохион байгууллаа. Сургуулийн өмнөх боловсролын хүрээнд хүүхдийн 8 цэцэрлэгт ажиллаж, 109 хүнд арга зүйн зөвлөгөө өгсөн бөгөөд сургалтын үйл ажиллагааны чанар 70-91 хувь, менежментийн үнэлгээ 81-86 хувьд | 100% |

**Эх сурвалж:** А.Мөнхжаргал /Статистикийн мэдээлэл, хяналт, шинжилгээ үнэлгээ хариуцсан ахлах арга зүйч/
Дорнод аймгийн Боловсролын газар, Бодлогын хэрэгжилтийн хэлтэс, 304 тоот, Емэйл: munkhjargal6lgv@moes.edu.mn Утас: 89336089

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хүрч, өмнөх жилээс 1-3 хувиар ахисан үзүүлэлттэй гарсан байна. Мөн бүлгийн болон биеийн тамир, хөгжмийн 57 багшийн үйл ажиллагаанд ажиглалт хийж, төлөвлөлтийг засаж сайжруулав. Ерөнхий боловсролын сургуулийн хүрээнд ерөнхий боловсролын 7 сургуульд ажиллаж, 194 багшийн хичээлд ажиглалт хийн, давхардсан тоогоор 445 багш, удирдах ажилтанд ганцаарчилсан зөвлөгөө өгч, 395 ажилтны бичиг баримтын бүрдэл, төлөвлөгөөтэй танилцан мэргэжил арга зүйн удирдлагаар хангалаа. Энэхүү үйл ажиллагааны үр дүнд байгууллагуудын ололт, сул талыг бодитой илрүүлж, сургуулийн | |

**Эх сурвалж:** А.Мөнхжаргал /*Статистикийн мэдээлэл, хяналт, шинжилгээ үнэлгээ хариуцсан ахлах арга зүйч/*
*Дорнод аймгийн Боловсролын газар, Бодлогын хэрэгжилтийн хэлтэс, 304 тоот, Емэйл: munkhjargal6lgv@moes.edu.mn Утас: 89336089*

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | менежментийн зураглал, төлөвлөгөөнд нэмэлт сайжруулалт хийх, багшлахуй болон суралцахуйн үйл ажиллагаанд ахиц гаргах гарц гаргалгаар тодорхойлсон үр дүнтэй дэмжлэг боллоо.<br>Хүрсэн түвшин: СӨБ - 8 ЕБС - 7<br>Хавсралт: 11 файл | |
| 3.5.4 | Боловсрол, сургалтын байгууллага, дотуур байранд орчны эрсдэлийн үнэлгээг хийж, орчны аюулгүй байдлын стандарт, эрүүл ахуйн стандарт болон дотуур байрын орчин, үйлчилгээний стандартын хэрэгжилтийг хангахад хяналт тавин ажиллана. | Зохион байгуулалтын арга хэмжээ | Хамруулсан байгууллагын хувиар | 100 | Эхний хагас жилд: 30<br>Жилийн эцэст: 100 | Боловсролын байгууллага, дотуур байрны орчны эрсдэлийг үнэлж, стандартын хэрэгжилтийг хангах чиглэлээр дараах ажлуудыг хэрэгжүүллээ. Сургуулиуд эрсдэлийн өөрийн үнэлгээг улирал тутам хийж хэвшсэн бөгөөд 2026 онд давхардсан тоогоор 40 удаа үнэлгээ хийж, давхардсан тоогоор 328 эрсдэл илрүүлснээс 252 | 100% |

**Эх сурвалж:** *А.Мөнхжаргал /Статистикийн мэдээлэл, хяналт, шинжилгээ үнэлгээ хариуцсан ахлах арга зүйч/*
*Дорнод аймгийн Боловсролын газар, Бодлогын хэрэгжилтийн хэлтэс, 304 тоот, Емэйл: munkhjargal6lgv@moes.edu.mn Утас: 89336089*

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | эрсдэл буюу 76.8%-ийг бүрэн арилгаад байна. Сургуулийн орчны аюулгүй байдлын стандартыг 46 асуулгаар үнэлэхэд 79.3%-тай хангагдсан бөгөөд үүнээс их эрсдэлтэй 2 (Сэргэлэн, Чулуунхороот сумын ЕБС), дунд эрсдэлтэй 7, бага эрсдэлтэй 14 сургууль үнэлэгдлээ. Дотуур байрны орчны үйлчилгээний стандартын үнэлгээнд хамрагдсан байрны 5 нь дунд, 10 нь бага эрсдэлтэй гарсан бөгөөд 37 шалгуур үзүүлэлтээр үнэлэхэд дотуур байруудын 46.7-60.0% нь биеийн тамирын талбай, дасгалын хэрэгсэл, галын дохиололгүй, 40.0-53.3% нь дулаан, ариутгах татуургын нэгдсэн сүлжээнд | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | холбогдоогүй, 46.7% нь номын сангийн ном хангамж дутмаг, 40% нь хөгжлийн өрөөндөө хөгжим, буйдангүй, 13.3% нь зурагтгүй, 60.0% нь компьютер болон сэтгэхүй хөгжүүлэх тоглоом наадгай хангалтгүй байгаа нийтлэг зөрчил илэрлээ. Мөн гүйцэтгэлийн үнэлгээний асуумжийн дагуу орчны эрсдэлийг цэцэрлэгийн түвшинд 28, сургуулийн түвшинд 62 асуумжаар үнэлэхэд сургуулийн өмнөх байгууллагууд 73-91%, ЕБС-иуд 85-92%-ийн биелэлттэй гарч, зөрчлийг тухай бүр засах чиглэл өгөв. Эрүүл ахуйн стандартын үнэлгээнд төрийн өмчийн 22 сургууль, 16 дотуур байр 100% бүрэн хамрагдаж, | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хүүхдийн амьдрах орчин, ариун цэвэр, хоол үйлдвэрлэл, ус хангамжийг шалган, илэрсэн нийтлэг 32 зөрчлийг арилгуулах чиглэл өгсөн байна. Түүнчлэн аймгийн Эрүүл мэндийн газартай хамтран томуу, томуу төст өвчин, улаанбурхнаас урьдчилан сэргийлэх чиглэлээр цэвэрлэгээ, халдваргүйтгэлд 3 удаа хяналт тавьж ажиллалаа. Стандартын хэрэгжилтийг хангах хүрээнд 42 удирдах ажилтан, эмч, албан хаагчдад зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж, эрсдэлгүй, хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэхэд дэмжлэг үзүүллээ. Хүрсэн түвшин: ЕБС-23, СӨБ-32, дотуур байр-16, нийт 71 боловсролын | |

**Эх сурвалж:** А.Мөнхжаргал /Статистикийн мэдээлэл, хяналт, шинжилгээ үнэлгээ хариуцсан ахлах арга зүйч/
Дорнод аймгийн Боловсролын газар, Бодлогын хэрэгжилтийн хэлтэс, 304 тоот, Емэйл: munkhjargal6lgv@moes.edu.mn Утас: 89336089

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | сургалтын байгууллага хамрагдсан.<br>Хавсралт: 8 файл | |
| Гурав. Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ | | | | | | | |
| 4.1. | Бүх шатны төрийн байгууллагын чадавхыг бэхжүүлж, төрийн албан хаагчдын сахилга, хариуцлагыг өндөржүүлэн, иргэд олон нийтэд төрийн үйлчилгээг ил тод, нээлттэй хүргэнэ. | Зохион байгуулалтын арга хэмжээ | Төлөвлөсөн арга хэмжээнүүдийн биелэлтийн хувиар | 100 | 100 | Зорилтын хүрээнд 7 арга хэмжээг төлөвлөн, хэрэгжилтийг 100 хувь ханган ажиллалаа. | 100% |
| 4.1.1 | Сургууль, цэцэрлэг, Боловсролын газарт иргэдээс ирсэн санал, өргөдөл, гомдлыг хуулийн хүрээнд бүрэн шийдвэрлэнэ. | Зохион байгуулалтын арга хэмжээ | Өргөдөл, гомдлыг шийдвэрлэсэн хувь | 100 | Эхний хагас жилд: 100<br>Жилийн эцэст: 100 | Аймгийн Засаг даргын дэргэдэх хэрэгжүүлэгч агентлаг Боловсролын газарт 2026 оны 1-6 дугаар сарын байдлаар иргэдээс төрийн байгууллага албан тушаалтанд хандаж нийт 15 өргөдөл, гомдол байна. Ирсэн өргөдөл, гомдлыг хугацаанд нь бүрэн шийдвэрлэж ажилласан байна. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Хүрсэн түвшин: 100<br>Хавсралт: 1 файл | |
| 4.1.2 | Аймгийн хэмжээнд багш, удирдах болон бусад ажилтныг ёс зүйгүй аливаа үйлдэл гарахаас урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулж үр дүнг тооцож ажиллана. | Зохион байгуулалтын нэгж | Хэрэгжилтийн хувиар | 100 | Эхний хагас жилд: 100<br>Жилийн эцэст: 100 | Аймгийн хэмжээний 26 сургууль, 32 цэцэрлэг бүрт багш, ажилтны ёс зүйн соёлыг бэхжүүлэх зорилгоор 5–7 хүний бүрэлдэхүүнтэй анхан шатны ёс зүйн дэд хороог тушаалаар шинэчлэн байгуулж, үйл ажиллагааг нь идэвхжүүлэв. “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай” хууль болон мэргэжлийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтийн хүрээнд 7 сургууль, 7 цэцэрлэгийг хамруулан удирдах ажилтны манлайлал, байгууллагын соёл, хандлагыг тандах асуулга судалгааг 400 гаруй албан хаагчаас авч, үр дүнгээр нь зөвлөмж хүргүүллээ. Мөн боловсролын багц | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хуулийн талаарх тандалт судалгаанд 360 гаруй багшийг хамруулан дүн шинжилгээ хийсэн бөгөөд харилцааны алдаа зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалтыг 2 удаа зохион байгуулж, Боловсролын газар болон сургууль, цэцэрлэгүүдийн цахим хуудсаар дамжуулан ёс зүйн мэдээлэл, хүүхэд хамгааллын зөвлөмжийг тогтмол түгээв. Түүнчлэн 21 сургууль хамт олны эерэг харилцаа, багийн ажиллагааг дэмжих олон талт үйл ажиллагааг тогтмолжуулж, сургуулийн нийгмийн ажилтан, сэтгэл зүйчид хамтран 18 сургуулийн 1500 багш, ажилтанд “Эерэг харилцааг өөрөөсөө” сэдэвт сургалт, дадлагыг хослуулан явуулснаар ажлын | |

**Эх сурвалж:** А.Мөнхжаргал /Статистикийн мэдээлэл, хяналт, шинжилгээ үнэлгээ хариуцсан ахлах арга зүйч/
Дорнод аймгийн Боловсролын газар, Бодлогын хэрэгжилтийн хэлтэс, 304 тоот, Емэйл: munkhjargal6lgv@moes.edu.mn Утас: 89336089

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байрандаа бие биенээ хүндэтгэх, ёс зүйн зөрчилгүй ажиллах хандлагыг нэмэгдүүллээ.<br>Хүрсэн түвшин: 100<br>Хавсралт: 2 файл | |
| 4.1.3 | Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, үндэсний хөтөлбөр, аймгийн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд удирдлага, арга зүйгээр хангана. | Зохион байгуулалтын арга хэмжээ | Хэрэгжилтийн хувь | 100 | Эхний хагас жилд: 100<br>Жилийн эцэст: 100 | Холбогдох хууль тогтоомж, үндэсний болон аймгийн дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах арга зүйн удирдамжийн хүрээнд харьяа байгууллагуудыг шат дараатай удирдлагаар ханган ажиллаж байна. Сургууль, цэцэрлэгүүд жилийн төлөвлөгөөгөө дотоод хурлаараа тогтмол хэлэлцэж хэвшсэн бөгөөд 2025-2026 оны хичээлийн жилд аймгийн хэмжээнд 26 сургууль, 32 цэцэрлэг дотоод журамдаа жендэрийн тэгш байдлыг хангах нэмэлт өөрчлөлтүүдийг | 100% |

**Эх сурвалж:** *А.Мөнхжаргал /Статистикийн мэдээлэл, хяналт, шинжилгээ үнэлгээ хариуцсан ахлах арга зүйч/*
*Дорнод аймгийн Боловсролын газар, Бодлогын хэрэгжилтийн хэлтэс, 304 тоот, Емэйл: munkhjargal6lgv@moes.edu.mn Утас: 89336089*

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тусган хэрэгжүүллээ. Энэхүү зохицуулалт нь хөдөлмөрийн харилцаанд ажилчдыг эрсдэлээс хамгаалах, тэдний санал гомдлыг шуурхай шийдвэрлэн ажлын байрны аятай таатай, аюулгүй орчныг бүрдүүлэхэд өндөр үр дүн үзүүлж байна. Сургалт, нөлөөллийн ажлын хүрээнд жендэрийн тэгш байдал, хэвшмэл ойлголт, ялгаварлан гадуурхалт болон хүчирхийллээс сэргийлэх чиглэлээр зохион байгуулсан танхимын сургалтуудад нийт 1465 сурагч, 318 багш ажилтан, 547 эцэг эхийг хамрууллаа. Мөн хүүхэд хамгаалал, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх видео | |

***Эх сурвалж:*** *А.Мөнхжаргал /Статистикийн мэдээлэл, хяналт, шинжилгээ үнэлгээ хариуцсан ахлах арга зүйч/*
*Дорнод аймгийн Боловсролын газар, Бодлогын хэрэгжилтийн хэлтэс, 304 тоот, Емэйл: munkhjargal6lgv@moes.edu.mn Утас: 89336089*

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | контентуудыг сургууль, цэцэрлэгийн цахим хуудсуудаар өдөр тутам түгээн ажиллав. "Технологи ашиглан үйлдэгдэж буй жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх 16 хоногийн аянд" Дорнод аймгийн 18 сургууль, 21 цэцэрлэг нэгдэж, аяны уриалга, мэдээллийг цахим орчинд тогтмол байршуулав. Хамт олны дунд эерэг уур амьсгал бүрдүүлэх, жендэрийн мэдлэгийг бататгах "Эртэч өглөө" үйл ажиллагаа, "Танин тунгаа" тэмцээнийг зохион байгуулж, бие биедээ урмын үгс бичих ажлыг өрнүүллээ. Мөн ахлах ангийнхны санаачилгаар "Үе тэнгийн дээрэлхэлтийг зогсооё" өдөрлөгт 7-10 дугаар ангийн 750 сурагчийг | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хамруулсан байна. Сургуулиудын жендэрийн багууд хүчирхийллийн эсрэг аян өрнүүлж, 123 бүлэгт яриа таниулга хийн суралцагчдын гарын үсгээр баталгаажууллаа. Түүнчлэн охидын болон мэтгэлцээний клубийн удирдсан багш нар хамтран “Охид эмэгтэйчүүд хаана ч аюулгүй - шалтаг бүү тооч”, нийгмийн ухааны багш нар “Жендэрийн тухай хэвшмэл ойлголт” сургалтуудыг тус тус зохион байгуулж, 60 бүлгийн 254 суралцагчийг хамруулан, урьдчилан сэргийлэх нөлөөллийн ажлыг амжилттай хэрэгжүүллээ.<br>Хүрсэн түвшин: 100<br>Хавсралт: 1 файл | |
| 4.1.4 | Ерөнхий | Зохион | Хэрэгжилтийн | 100 | Эхний хагас жилд: | Ерөнхий | 100% |

**Эх сурвалж:** А.Мөнхжаргал /Статистикийн мэдээлэл, хяналт, шинжилгээ үнэлгээ хариуцсан ахлах арга зүйч/
Дорнод аймгийн Боловсролын газар, Бодлогын хэрэгжилтийн хэлтэс, 304 тоот, Емэйл: munkhjargal6lgv@moes.edu.mn Утас: 89336089

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | боловсрол, хүүхдийн цэцэрлэг, мэргэжлийн боловсролын байгууллагын хэвийн үйл ажиллагааг доголдуулахгүй байх, өмч хөрөнгийг зориулалтын дагуу ашиглах, тогтмол зардлын өр үүсгэхгүй байх, барилга байгууламж, техник, тоног төхөөрөмжийн засвар, үйлчилгээний зардлыг хуваарилан хэрэгжүүлнэ. | байгууллалтын арга хэмжээ | хувиар | | 100 Жилийн эцэст: 100 | боловсролын сургууль, хүүхдийн цэцэрлэг, мэргэжлийн боловсролын нийт 55 байгууллагын хэвийн үйл ажиллагааг доголдуулахгүй байх, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлын өр үүсгэхгүй байх чиглэлд санхүүгийн сахилга батыг ханган ажиллаж байна. 2026 онд тогтмол зардал болон урсгал засварт нийт 6,224.0 сая төгрөг батлагдсанаас эхний 4 дүгээр сарын байдлаар 3,403.3 сая төгрөгийн санхүүжилтийн төлөвлөгөөтэй ажилласнаас 3,372.6 сая төгрөгийг олгож, зарлагын гүйцэтгэл 3,100.7 сая төгрөг буюу 91.9 хувьтай байна. Ингэснээр боловсролын | |

***Эх сурвалж:*** *А.Мөнхжаргал /Статистикийн мэдээлэл, хяналт, шинжилгээ үнэлгээ хариуцсан ахлах арга зүйч/*
*Дорнод аймгийн Боловсролын газар, Бодлогын хэрэгжилтийн хэлтэс, 304 тоот, Емэйл: munkhjargal6lgv@moes.edu.mn Утас: 89336089*

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байгууллагуудын өмч хөрөнгийг зориулалтын дагуу ашиглах, инженерийн дэд бүтцийн тасралтгүй байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлж, төсвийн хуваарилалтыг үр дүнтэй хэрэгжүүллээ.<br>Хүрсэн түвшин: 100 хувь<br>Хавсралт: 1 файл | |
| 4.1.5 | Боловсролын салбарын төсвийн шинэчлэл, цахим шилжилттэй холбоотой үйл ажиллагааг дэмжиж ажиллах, холбогдох тооцоо судалгаа, цахим төсвийн төслийн үйл ажиллагааг орон нутагт зохион байгуулна. | Зохион байгуулалтын арга хэмжээ | Хэрэгжилтийн хувиар | 100 | Эхний хагас жилд: 100<br>Жилийн эцэст: 100 | Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгүүдийн удирдах ажилтны мэдээллийн цагаар 4 удаа, нягтлан бодогч нарт цахим уулзалтыг 7 удаа зохион байгуулж, төсөв санхүүгийн холбогдох хууль, тогтоомж, чиглэл, аргачлал, мэдээллийг хүргэн ажиллалаа. Багш, ажилтанд мөнгөн тэтгэмж олгох журмын хүрээнд 2026 онд 381 | 100% |

**Эх сурвалж:** *А.Мөнхжаргал /Статистикийн мэдээлэл, хяналт, шинжилгээ үнэлгээ хариуцсан ахлах арга зүйч/*
*Дорнод аймгийн Боловсролын газар, Бодлогын хэрэгжилтийн хэлтэс, 304 тоот, Емэйл: munkhjargal6lgv@moes.edu.mn Утас: 89336089*

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | багшид 328.7 сая төгрөгийн гүйцэтгэлийн үнэлгээний урамшуулал олгож, тэтгэвэр болон тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмж авах 73 албан хаагчийн 813.8 сая төгрөгийн санхүүжилтийн тооцоог нэгтгэн нэхэмжлэлийг дээд шатны байгууллагад хүргүүлж, санхүүжилт авсан. Засгийн газрын 151 дүгээр тогтоол болон Боловсролын сайдын А/20 дугаар тушаалын хэрэгжилтийг ханган, төрийн үйлчилгээний албан хаагчдын үндсэн цалинг 50 хувь нэмэгдүүлсэн дүнгээр тооцож, эхний 5 дугаар сарын байдлаар аймгийн хэмжээний 55 байгууллагад нийт 40,524.7 сая төгрөгийн цалин | |

**Эх сурвалж:** А.Мөнхжаргал /Статистикийн мэдээлэл, хяналт, шинжилгээ үнэлгээ хариуцсан ахлах арга зүйч/
Дорнод аймгийн Боловсролын газар, Бодлогын хэрэгжилтийн хэлтэс, 304 тоот, Емэйл: munkhjargal6lgv@moes.edu.mn Утас: 89336089

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хөлсийг цаг хугацаанд нь олгож, шинэчлэгдсэн журам шийдвэрийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.<br>Хүрсэн түвшин: 100<br>Хавсралт: 1 файл | |
| 4.1.6 | Мэдээллийн технологийн бодлогын хэрэгжилтийг хангах, мэдээллийн сан бүрдүүлэх, статистик мэдээ гаргах, хэрэглэгчдийг мэдээллээр хангана | Зохион байгуулалтын арга хэмжээ | Мэдээлийн санд оруулсан маягт, мэдээллийн тоо | ЕБС-75 маягт, СӨБ-27 маягт | Эхний хагас жилд: ЕБС-45 маягт, СӨБ-19 маягт Жилийн эцэст: ЕБС-30 маягт, СӨБ-8 маягт | Аймгийн сургуулийн өмнөх боловсролын 32 байгууллагын Ерөнхий мэдээллийн тайланг анхан шатны 7, захиргааны 8 маягтаар, Сургалтын орчин, Ус, ариун цэврийн тайланг анхан шатны 2, захиргааны 2 маягтаар, Үндсэн хөрөнгө, Төсвийн орлого, зарлагын гүйцэтгэлийн тайланг анхан шатны 2, захиргааны 6 маягтаар, нийт 27 маягтаар, Ерөнхий боловсролын 26 сургуулийн Ажилтан, суралцагч, бүлэг, дүрэмт хувцасны | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тайланг 37 маягтаар, Сурах бичиг, сурдаггүй хүүхдийн тайланг 6 маягтаар, Сургалтын орчин, номын сангийн тайланг 2 маягтаар, Нийт хөрөнгө, Төсвийн орлого, зарлагын гүйцэтгэлийн тайланг 15 маягтаар статистик мэдээг гаргахад хяналт тавьж, мэдээллийн сан бүрдүүлсэн. Хууль дүрэмд заасан хугацаанд тайлагнаж ажиллаж байна.<br>Хүрсэн түвшин: ЕБС-75 маягт, СӨБ-27 маягт<br>Хавсралт: 1 файл | |
| 4.1.7 | Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан мэдээллийг нийтэд байршуулж, хэрэгжилтийг ханган ажиллана. | Зохион байгуулалтын арга хэмжээ | Хэрэгжилтийн хувь | 91 | Эхний хагас жилд: 92<br>Жилийн эцэст: 93 | Нийтийн мэдээллийн ил тод байдлыг хангах shilem.gov.mn болон төрийн мэдээллийн gov.mn нэгдсэн системд 5 бүлгийн 78 үзүүлэлтээс өөрийн байгууллагын чиг | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | үүрэгт хамаарал бүхий 44 үзүүлэлтийг 2026 оны 1,2-р улиралд бүрэн тайлагнасан. 2026 оны 1-р улирлын үзүүлэлтээр 92.99 хувьтай үнэлэгдсэн. Байгууллагын вэб хуудсанд 1-р улиралд 26, 2-р улиралд 25 мэдээллийг оруулж, боловсролын салбарын мэдээ мэдээллийг түгээсэн байна.<br>Хүрсэн түвшин: 92.99<br>Хавсралт: 2 файл | |
| 4.2. | Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх соёлыг төлөвшүүлж, албан хаагчдын ёс зүй, хариуцлагын тогтолцоог бэхжүүлнэ. | Зохион байгуулалтын арга хэмжээ | Төлөвлөсөн арга хэмжээнүүдийн гүйцэтгэлийн хувиар | 100 | 100 | Зорилтын хүрээнд 3 арга хэмжээг төлөвлөн, хэрэгжилтийг 100 хувь хангаж ажиллалаа. | 100% |
| 4.2.1 | Авлигатай тэмцэх газрын гомдол мэдээлэл хүлээн авах 110 дугаар 1-110 болж | Зохион байгуулалтын арга хэмжээ | Сургалт, нөлөөллийн ажлын тоо | 4 | Эхний хагас жилд: 2<br>Жилийн эцэст: 3 | Боловсролын салбарын байгууллагуудад зөвлөн туслах ажлын явцад албан | 100% |

**Эх сурвалж:** А.Мөнхжаргал /Статистикийн мэдээлэл, хяналт, шинжилгээ үнэлгээ хариуцсан ахлах арга зүйч/
Дорнод аймгийн Боловсролын газар, Бодлогын хэрэгжилтийн хэлтэс, 304 тоот, Емэйл: munkhjargal6lgv@moes.edu.mn Утас: 89336089

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | өөрчлөгдсөн талаарх мэдээллийг иргэд, олон нийтэд ойлгомжтой, хүртээмжтэй байдлаар мэдээлэх, байгууллагын цахим хуудас болон бусад сүлжээгээр тогтмол сурталчлах, авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, тэдэнд авлигыг үл тэвчих ёс суртахуун төлөвшүүлжх, уг ажиллагаанд тэднийг татан оролцуулах арга хэмжээг зохион байгуулна. | | | | | хаагч, багш, ажилтнуудад “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”-ийн талаар цахим сургалт зохион байгуулж, 13 сумын сургуулийн давхардсан тоогоор 3100 ажилтан албан хаагч оролцлоо. Нийт оролцогчдод болон байгууллагын мэргэжилтнүүдэд Монгол Улсын Авилгатай Тэмцэх Газраас гаргасан “Нийтийн албан тушаалтнуудад зориулсан гарын авлага” “Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэг гаргагч нарт зориулсан гарын авлага“, Нийтийн ашиг сонирхол гэж юу вэ? боршур, | |

***Эх сурвалж:*** *А.Мөнхжаргал /Статистикийн мэдээлэл, хяналт, шинжилгээ үнэлгээ хариуцсан ахлах арга зүйч/*
*Дорнод аймгийн Боловсролын газар, Бодлогын хэрэгжилтийн хэлтэс, 304 тоот, Емэйл: munkhjargal6lgv@moes.edu.mn Утас: 89336089*

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | “Авлигын эсрэг хууль тогтоомжийг таниулах нь” видео танилцуулгыг мэдээллээр хүргэн салбарын бүх албан хаагчдад сурталчилсан. Иргэд, эцэг эх, төрийн албан хаагчдад хуулийн танилцуулга, мэдээлэл өгөх зорилгоор Зөрчлийн тухай хууль, Авлигатай тэмцэх тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг мэдээлийн самбарт байршуулах, хуулийг хэрэгжүүлэх, ашиг сонирхолоос ангид байх, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 9 | |

***Эх сурвалж:*** *А.Мөнхжаргал /Статистикийн мэдээлэл, хяналт, шинжилгээ үнэлгээ хариуцсан ахлах арга зүйч/*
*Дорнод аймгийн Боловсролын газар, Бодлогын хэрэгжилтийн хэлтэс, 304 тоот, Емэйл: munkhjargal6lgv@moes.edu.mn Утас: 89336089*

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | дүгээр зүйлийн 9.1, Авлигатай тэмцэх газрын даргын 2026 оны “Хуулийн хэрэгжилт хангуулах тухай” албан бичиг, Боловсролын ерөнхий газрын даргын 2026 оны “Хариу арга хэмжээ авах тухай” албан бичгийг боловсролын сургалтын байгууллагын удирдлагуудад мэдээлэл, сургалтыг хийж, зөвлөмж чиглэлийг албан бичгээр хүргүүлсэн.<br>Хүрсэн түвшин: 3<br>Хавсралт: 1 файл | |
| 4.2.2 | Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшигчийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг (ХАСУМ) хянуулах, албан хаагчдын ХАСХОМ-ийг | Зохион байгуулалтын арга хэмжээ | ХАСХОМ мэдүүлсэн албан хаагчдын тоо | 179 | Эхний хагас жилд: 110<br>Жилийн эцэст: 110 | Боловсролын салбарын удирдах ажилтан болон Боловсролын газрын ахлах арга зүйч нарын “Хувийн ашиг сонирхолын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн бүрдүүлэлтийн | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хуулийн хугацаанд мэдүүлэх ажлыг бүрэн хангаж, ашиг сонирхлын зөрчилгүй ажиллах нөхцөлийг бүрдүүлнэ. | | | | | систем" шинэчлэгдсэнтэй холбоотой ХАСХОМ хэрхэн бүртгүүлэх талаар анхаарах асуудал сэдвээр сургалт зохион байгуулж, 2026 оны 02 дугаар сарын 15-ны дотор 109 албан хаагчийн ХАСХОМ-ийг бөглүүлж баталгааны маягтаар баталгаажуулж авлаа. Мөн шинээр томилогдож байгаа 5 албан хаагчийн ХАСУМ хянуулан томилуулахад арга зүй, зөвлөмжөөр хангаж ажиллаж байна.<br>Хүрсэн түвшин: 109<br>Хавсралт: 1 файл | |
| 4.2.3 | Төрийн үйлчилгээний төсвийн шууд захирагч нарын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан | Зохион байгуулалтын арга хэмжээ | Харьяалагдах сургууль, цэцэрлэгүүдийн удирдлагатай авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусган байгуулсан гэрээний тоо | 53 | Эхний хагас жилд: 53<br>Жилийн эцэст: 53 | Сургуулийн өмнөх боловсролын 31 байгууллага, Ерөнхий боловсролын 23 сургуулийн захирал, эрхлэгч нарын Байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 4 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | сэргийлэх тусгайлсан заалт тусгаж, биелэлтийг хагас, бүтэн жилээр дүгнэх | | | | | дүгээр хэсгийн 4.1.2, 4.1.3 дэх заалтуудыг тусган хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.<br>Хүрсэн түвшин: 52<br>Хавсралт: 1 файл | |

*Үнэлсэн:* .........................

......................................... ......................... /................................./

*(албан тушаал )* *(гарын үсэг)*

.........................

*(огноо)*

*Тайлагнасан:* .........................

......................................... ......................... /................................./

*(албан тушаал )* *(гарын үсэг)*

.........................

*(огноо)*

**Эх сурвалж:** *А.Мөнхжаргал /Статистикийн мэдээлэл, хяналт, шинжилгээ үнэлгээ хариуцсан ахлах арга зүйч/*
*Дорнод аймгийн Боловсролын газар, Бодлогын хэрэгжилтийн хэлтэс, 304 тоот, Емэйл: munkhjargal6lgv@moes.edu.mn Утас: 89336089*